



УУРХАЙН ГАДААД БҮСЭД БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЛИЙН ХЯНАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх, үл нийцэл илэрсэн даруйд авах арга хэмжээг зохицуулахад оршино.
- 1.2. Хяналт шалгалтын хамрах хүрээ нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбай, хүдэр, баяжмал тээвэрлэдэг замын маршрут, гэрээт компаниудын үйл ажиллагаа явуулж буй объектууд, тээврийн зам, уурхайг цахилгаанаар хангах шугам дагуух талбай хамаарна.
- 1.3. “Гадаад бүс” гэж “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн бүсээс гадуурх үйл ажиллагааны шууд болон дам нөлөөлөлд өртөх эрсдэлтэй талбай, тусгай зөвшөөрлийн хил доторх талбайг хамруулан ойлгоно.

Хоёр. Хяналт шалгалт хийх горим

- 2.1. Хяналт шалгалтыг хоёроос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй явуулна.
- 2.2. Хяналтад гарахдаа аюулгүй ажиллагааны дүрэм, журам, горим, зааврыг баримтална.
- 2.3. Хяналт шалгалтын үед зөрчлийг баримтжуулан тайлан боловсруулна.
- 2.4. Гадаад бүсэд хийх хяналт шалгалтын цэгүүдийг улирлын эхэнд богино хугацааны төлөвлөлтөд тусгана.
- 2.5. Уурхайн гадаад бүсийн хяналт шалгалтыг сард нэгээс доошгүй удаа явуулна.
- 2.6. Цаг агаарын аюултай үзэгдэл, цаг агаарын эрс тэс өөрчлөлттэй үед хяналт шалгалт явуулахгүй.
- 2.7. Хяналт шалгалтыг хийхдээ аль болох олон төлөөллийг оролцуулахыг эрмэлзэнэ.
- 2.8. Хяналт шалгалтын үед үүсэж болох маргаанаас зайлсхийж, харилцааны ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллана.

Гурав. Үл нийцэл, мэдээлэл

- 3.1. Илэрсэн зөрчил ноцтой бол компанийн Хуулийн хэлтэст хандаж холбогдох шатны хууль, хяналтын байгууллагад мэдээлнэ.
- 3.2. Тус хяналт шалгалтаар дараах байгаль орчны үл нийцлийг илрүүлж зөрчлийг зохих байгууллагад мэдэгдэж арга хэмжээ авахыг зорино.
 - Бохир ус асгаж малын бэлчээр доройтуулж, бохирдуулсан;
 - Үхсэн малын сэг, зэм ихээр хаяж орчныг бохирдуулсан;
 - Шалтгаан нь тодорхой мал, амьтан үхсэн;
 - Мал хулгайлж, бэлчээрт бой хийсэн;
 - Замгүй газраар зорчиж, бэлчээрийн доройтолд хүргэсэн;
 - Малчны худаг усыг санаатай болон санамсаргүйгээр бохирдуулсан, худгийн эд зүйлсийг эвдсэн;
 - Хээр их хэмжээний хог хаягдал хаяж, орчныг бохирдуулан хогийн цэг шинээр үүсгэсэн;
 - Түлш, тос тослох материалын хог хаягдал ихээр үүсгэсэн.

Дөрөв. Бүртгэл, мэдээ тайлан

- 4.1. Илэрсэн зөрчил мэдээллийг баримтжуулан бүртгэл үүсгэж, тухайн үл нийцлийг шийдвэрлэсэн эсэхийг байнга хянаж, үл нийцлийг арилгуулах арга хэмжээ авна.

- 4.2. Хяналт шалгалтад гарсан тухай, шалгалтын явцад илрүүлсэн зөрчил, залруулах арга хэмжээ, тайлагнасан хэлбэртэй холбоотой маягт боловсруулж, тогтмол мөрдүүлж ажиллана.

Тав. Хариуцлага

- 5.1. Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

Хяналт шалгалтын цэгийн байршил: _____
 Шалгалт хийгдсэн огноо: _____
 Цаг: _____
 Цаг агаарын төлөв байдал: _____

Байгаль орчны үл нийцэл	
Үл нийцлийн тодорхойлолт	
Шалтгаан	
Залруулах арга хэмжээ	
Тухайн үеийн нөхцөл байдал	
Зөрчил гаргасан ажилтны нэр, албан тушаал	
Цааш мэдэгдэх эсэх	Тийм ☐ Үгүй ☐
Хор хохирлын хэмжээ	


Багийн бүрэлдэхүүн:

д/д	Нэр	Албан тушаал	Гарын үсэг

Уурхайн гадаад бүсэд байгаль
орчны нийцлийн хяналт хийх
журмын хоёрдугаар хавсралт



Тухайн үеийн нөхцөл байдлын зураг:



Журмын хяналтын хуудас

Баримт бичгийн нэр	Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам
Баримт бичгийн код	ЭАР-БО-Ж01-И/18
Тодорхойлолт	"Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх, үл нийцэл илэрсэн даруйд авах арга хэмжээг зохицуулна.
Анхны зохиогч	Ш.Намсрайжав, Г.Анх-Амгалан /Байгаль орчны мэргэжилтэн
Үүсгэсэн огноо	
Баталсан албан тушаалтан*	
Баталсан огноо*	

Нэмэлт өөрчлөлт

Хувилбар	Хянан засварласан огноо	Хянасан	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1				
2				
3				
4				

* Журам, горим, зааврын хамгийн эхний хувилбарыг баталж буй тохиолдолд бөглөнө.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхай болон нөлөөллийн бүсэд агаар, ус, хөрс, ургамлын хяналт шинжилгээ хийх ажлын харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь уурхайн бүх нэгж, хэсэг, туслан гүйцэтгэгч гэрээт компани, тэдгээрийн ажилтнууд, түр зочдод нэгэн адил хамаарна.

Хоёр. Нэр томьёоны тайлбар

- 2.1 “Хүрээлэн буй орчны мониторинг” гэдэг нь байгаль орчны хяналт, шинжилгээ хийхийг;
- 2.2 “Агаарын чанар” гэж агаарын чанарын стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанарыг;
- 2.3 “Агаарын чанарын хяналт шинжилгээ” гэж агаарын чанарын төлөв байдал, түүний өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж үнэлэх үйл ажиллагааг;
- 2.4 “Агаарын чанарын стандарт” гэж хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулах бодисын хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хүлцэх хэм хэмжээг стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсныг;
- 2.5 “Усны чанар” гэж усны чанарын стандартад нийцэх эсэхийг илэрхийлэх физик, хими, биологийн цогц шинж чанарыг;
- 2.6 “Усны чанарын стандарт” гэж усны физик, хими, биологийн шинж чанарын үзүүлэлтүүд нь хүний эрүүл мэнд, усан орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хэм хэмжээг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсныг;
- 2.7 “Хаягдал ус” гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч байгаа бохир ус, шингэн хаягдлыг;
- 2.8 “Хаягдал усны стандарт” гэж усны бохирдлын эх үүсвэрээс гарч байгаа хаягдал усанд байж болох бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсныг;
- 2.9 “Төлөөлөгч” гэж оролцогч талаас хуваарьт хяналт, шинжилгээнд оролцохоор мэдүүлсэн иргэнийг;
- 2.10 “Хамтын оролцоот мониторинг” гэж орон нутаг сонирхогч талуудын оролцоотойгоор гүйцэтгэх байгаль орчны хяналт шинжилгээг;

Гурав. Хяналт хийх орчин, үзүүлэлтийг сонгох

- 3.1 Үйлдвэрийн сөрөг нөлөөлөл, дэлхийн дулаарал, олон жилийн давтамжтай байгаль, цаг уурын өөрчлөлтийн индикатор болохуйц үзүүлэлтүүдийг байгалийн бүрэлдэхүүн хэсгээс сонгоно.
- 3.2 Байгалийн бүрэлдэхүүн тус бүрд үзүүлж байгаа нөлөөг 5 жил тутам байгаль орчинд учруулах нөлөөллийн судалгаагаар шинэчлэн тогтооно.
- 3.3 Уурхайн үйл ажиллагаанаас агаар мандалд үзүүлж байгаа сөрөг нөлөө, хүний эрүүл мэндэд учруулах эрсдэлийг тогтоох зорилгоор агаар мандал дахь тоосонцрын нарийн болон том ширхэглэлийг хэмжинэ.
- 3.4 Үйлдвэрлэл, тээврийн үйл ажиллагааны нөлөөг тогтоох зорилгоор хөрсний бичил химийн үзүүлэлтийг шалгана.

- 3.5 Органик бохирдлыг тогтоох зорилгоор хөрс, усан орчинд агуулагдаж байгаа хүнд металл, нянгийн агууламжийг тогтооно.

Дөрөв. Цаг агаарын үзүүлэлтийн мэдээ цуглуулах

- 4.1. Цаг уурын үзүүлэлтийг дараах зорилгоор хэмжиж тогтооно. Үүнд:
- 4.1.1. Уурхайн аюулгүй ажиллагааг хангах цаг уурын онц ноцтой үзэгдлийг даван туулах
 - 4.1.2. Нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад үнэмлэхүй үзүүлэлтийг тэсвэрлэх нөхцөлийг цаг алдалгүй хангах
 - 4.1.3. Орчны хяналт шинжилгээгээр хэмжиж цуглуулсан мэдээ болон цаг уур, уур амьсгалын өөрчлөлтийн хооронд хамаарал, зүй тогтлыг судлан тогтоох
- 4.2. Цаг уурын үзүүлэлтийг хэмжихдээ зах зээлд өргөн тархсан, орчин цагийн хамгийн дэвшилттэй, олон улсын стандартад нийцсэн технологийг ашиглана.
- 4.3. Цаг уурын чухал үзүүлэлтүүд нь нарны цацраг, салхины хурд, салхины чиглэл, хур тунадас, ууршилт, агаарын үнэмлэхүй чийг, харьцангуй чийг, хөрсний чийг, агаарын даралт, агаарын хэм болно.
- 4.4. Цаг уурын үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн өндөр хурдыг харгалзан жилийн бүх өдөр, үзүүлэлт тус бүрээс хамааран 1-5 минутын давтамжтайгаар, тасралтгүй, тус журмын Хавсралт 4-т заасан хамгийн бага шаардлагад нийцсэн нарийвчлалаар хэмжинэ.

Тав. Усан орчны хяналт, шинжилгээ

- 5.1 Усны чанарын шинжилгээ
- 5.1.1 Усны чанарын шинжилгээг уурхайн ашиглалтын худгууд, малчны худгууд болон цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир усанд хийх ба цэгүүдийг сонгох болон шинжилгээ хийлгэх үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо тухайн оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тухайн оны Ус ашиглах гэрээнд заагдсан үзүүлэлтүүдийг уялдуулан сонгоно.
 - 5.1.2 Шинжилгээг хийлгэхдээ итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулан усны чанарын хими-физик, нян, бохирдлын үзүүлэлтүүдийг тодорхойлуулна.
 - 5.1.3 Монгол улсын ундны усны стандарт MNS 0900:2018, MNS 4943:2015, усны чанар, дээжлэлтүүдийн заавар, зөвлөмж (дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж MNS (ISO) 4867:99, дагаж мөрдөнө.
 - 5.1.4 Шинжилгээний хариуг нэгтгэн нэгдсэн мэдээллийн санд хадгална.
 - 5.1.5 Усны дээж авах үед тус журмын Хавсралт 1-д заасан “Усны дээж бэлтгэх, шинжилгээнд хүргүүлэх ажлын заавар”-ыг мөрдөж ажиллана.
- 5.2 Газар доорх усны хэсэгчилсэн мэдээлэл цуглуулах
- 5.2.1 Уурхайн үйл ажиллагааны усан орчинд үзүүлэх нөлөөг судлахад шаардагдах мэдээллийг цуглуулах зорилгоор уурхайн хэрэгцээний нийт өрөмдмөл худгуудад болон нөлөөллийн бүсийн зарим уст цэгүүдэд тус журмын Хавсралт 2. шаардлагын дагуу мониторингийн станц байгуулна.
 - 5.2.2 Уурхайн ажилтанд ойрын хугацаанд өртөхгүй хяналтын цэг, нөлөөллийн бүсийн уст цэгт мониторингийн станц байгуулахдаа орон нутгийн захиргааны холбогдох мэргэжилтэн, нутгийн иргэдтэй зөвшилцөж ашиглалтын явцад мэдээлэл солилцоно.
 - 5.2.3 Уурхайн дотоод хяналтын цэгүүдийг олон жилийн хугацаанд мэдээлэл авах боломжийг харгалзан тухайн талбайн гидрогеологийн судалгаанд үндэслэн цэгүүдийг сонгоно.

Зургаа. Хөрсний чанарын хяналт, шинжилгээ

- 6.1 Тухайн бүс нутгийн хүрээнд зонхилох тархсан хөрсний хэв шинжийг бүрэн төлөөлөх боломжтой хөрсний мониторингийн цэгүүдийг сонгон авна.
- 6.2 Итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулж хөрсний хими, физик шинж чанар, хүнд элементийн бохирдол, нянгийн бохирдлыг тухай оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан давтамжийн дагуу шинжлүүлнэ.
- 6.3 Шинжилгээний үр дүнг өмнөх онуудын дүнтэй харьцуулж өөрчлөлтийг тогтооно.
- 6.4 Хөрсний дээж авах үед Хавсралт 3. "Хөрсний дээж авах заавар"-ыг мөрдөж ажиллана.

Долоо. Орчны хяналт шинжилгээнд олон нийтийн оролцоог хангах

- 7.1 Хамтын оролцоот мониторингд оролцогч иргэн байгаль орчны мэргэжилтний хээрийн дээжлэлт, гадаад орчны хэмжилт явуулах хугацаанд биечлэн байлцах боломжоор хангана.
- 7.2 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан хэмжилт, шинжилгээний хуваарийг оролцогч талуудад хүргүүлж төлөөлөгч оролцуулна.
- 7.3 Хамтын оролцоот мониторингийн хөтөлбөр болон хэмжилт, шинжилгээний аргачлал, тоног төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглах зааврыг олон нийтэд нээлттэй, ил тод байна.
- 7.4 Хуваарьт хяналт, шинжилгээг явуулах боломжгүй болсон даруйд цуцлагдсан шалтгаан бүхий тайлбартайгаар олон нийтэд ялангуяа оролцохоор сонгогдсон төлөөлөгчдөд мэдээлнэ.
- 7.5 Хяналт, шинжилгээний үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.
- 7.6 Оролцогч талаас орчны хяналт шинжилгээний хуваарьт хэмжилт, дээжлэлтэд оролцуулах иргэн, албан тушаалтны нэр, холбоо барих мэдээллийг хуваарьт өдрөөс 5 хоногийн өмнө хүргэнэ.
- 7.7 Оролцогч талуудын төлөөллөөс адил тэгш оролцуулах зарчмыг баримтална.
- 7.8 Төлөөлөгчдийн хяналт, шинжилгээний хуваарьт өдөр оролцуулах хүний тоо зөвхөн тээвэрлэх боломжоор хязгаарлагдана.
- 7.9 Нөлөөллийн бүсийн иргэдийн оролцоо уурхайн бүсээс гадуур хяналт, шинжилгээнд үргэлж нээлттэй байна.

Найм. Хэмжилтийн баталгаажуулалт ба үнэн зөв байдал

- 8.1 Хэмжилтийн үр дүнг бодитой байлгах, олон нийтэд үнэн зөв мэдээлэх зорилгоор хэмжилт хийх үедээ холбогдох стандарт, аргачлалыг нарийн чанд мөрдөнө.
- 8.2 Хэмжилтийн бүх багажийн үйлдвэрээс заасан баталгаажуулалтыг заавал хийлгэх шаардлагатай.
- 8.3 Дээж, сорьцыг лабораторид хүргэхдээ дубликат дээжийг давхар хяналтын лабораторид хүргэх боломжийг байнга судалж хэрэгжүүлнэ.
- 8.4 Хэмжилтийн алдааг бага байлгах, үнэн зөв мэдээ баримт цуглуулах шаардлагаар хэмжилтийг гүйцэтгэгч мэргэжилтэн, оролцогч нар хангалттай түвшинд бэлтгэгдсэн байхаас гадна мэргэжилтэн тус бүрийг чиглэлээр сертификаттай байна.

Ес. Хариуцлага

- 9.1 Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.



Усны дээж бэлтгэх, шинжилгээнд хүргүүлэх ажлын заавар

1. Дээж авах үед аюулгүй ажиллагааг хангаж ажиллана, өндөр эрсдэлтэй тохиолдолд дээж авахыг хориглоно.
2. Усны дээжийн шошгод дараах мэдээллийг бичиж тэмдэглэнэ. Үүнд:
 - Байршил эсвэл объект
 - Дээж авсан огноо, цаг
 - Дээж авсан хүний албан тушаал, овог нэр
3. Усны дээж цуглуулсан мөчөөс лабораторийн шинжилгээнд хүргэх хүртэл 1-5 цельсийн хэмийн орчинд хадгалж 8-с дээшгүй цагт багтаан тээвэрлэнэ.
4. Багц дээжийг лабораторид хүргэхдээ протокол үйлдэж хавсаргана. Протоколд дээж тус бүрд хийгдэх шинжилгээний үзүүлэлт, дээжийн хэмжээ, тэмдэглэгээг бичиж гарын үсэг зурж баталгаажуулна.
5. Дээж авсан үед тусгай маягт хөтөлж лабораторид хүргэхдээ протокол хөтөлнө.
6. Дээжийн сав болон дээж авах дараалал:

Төвлөрсөн болон худгийн уснаас дээж авах

Лаборатори / Дээж авах сав	Эх үүсвэр	Дээж авах дараалал
Химийн лаборатори / Полиэтилен сав	Төвлөрсөн ус	Дээж авахдаа усыг сайтар гоожуулна. /1.5 л усыг дээжийн саванд хийнэ/
	Худаг	Худгийн усны шавхалтыг сайн хийж усны ундаргаас авна. /1.5л усыг дээжийн саванд хийнэ/
Нян судлалын лаборатори/ Ариун шил	Төвлөрсөн ус	Цоргыг спирт шингээсэн хөвөнт бамбарын дөлөөр 1 минутын турш халааж ариутгана. Цоргыг нээж усыг 10-15 минут гоожуулна. Усыг бөглөөнд хүрэхгүй байхаар 5-6 см зай үлдээж хийсний дараа бөглөнө.
	Худаг	Усны төвшнөөс 20-30 см-ийн гүнээс дээжийг авна. Ариун шилээ живүүлж чулууг оосрын үзүүрт уяна. Шилээ худгийн хана болон ёроолд хүргэлгүй авна.



Бохир уснаас дээж авах

Лаборатори	Дээж авах сав	Эх үүсвэр
Химийн	Полиэтилен сав	Цэвэрлэх байгууламжийн оролт
		Цэвэрлэх байгууламжийн гаралт
Нян судлалын	Ариун шил	Цэвэрлэх байгууламжийн оролт
		Цэвэрлэх байгууламжийн гаралт

Мониторингийн станцын хамгийн бага шаардлага

Уст цэгийн усны түвшний өөрчлөлтийг хянах зорилгоор автомат усны түвшин хэмжигч байрлуулах тохиолдолд төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Төхөөрөмжийг усан орчинд байгаа байдлаар нь 10-с доошгүй жил ашиглах боломжтой
- Төхөөрөмж нь усны түвшний мэдээллийг усны даралтыг мэдрэх зарчмаар нарийвчлалтайгаар хэмжиж өгөгдсөн давтамжтайгаар тогтмол бичлэг хийдэг, хадгалагдсан мэдээллийг авахад хялбар байх
- Төхөөрөмж усны орчны температурыг давхар хэмждэг байх, цельсийн хасах температурт хэмжих боломжтой /нэмэлт зааварчилгаатай/ байх.
- Төхөөрөмжийн насыг уртасгах, аюулгүй байдлыг хангах хийц, дизайнтай, цоож түгжээ, хамгаалалттай байна





Хөрсний дээж авах заавар

- Хөрснөөс шинжилгээнд дээж авахдаа тухайн газрын хөрсний шаардлагатай бүх үе давхаргыг бүрэн төлөөлж чадахаар байгаа хэсэг газрыг сонгож авна.
- Хөрсний дээж авах хөрсөнд 20-30 см гүн зүсэлт хийж хөрсний үеийг тодорхойлон үе тус бүрээс 300-500 гр хөрсний дээж авч сайтар холино.
- Хүнд элемент болон нянгийн бохирдлын хувьд дугтуйн аргаар буюу 1 м² талбай сонгон 4-н захын болон төвийн хэсгээс 50 гр орчим шороо цуглуулан холих маягаар дээж авна.
- Шинжилгээнд дээж авах хөрсний давхарга гүний хэмжээ нь шинжилгээний зорилго, хөрсний бохирдолтын байдлаас хамааран цэг тус бүрд адилгүй байж болно.
- Хөрснөөс шинжилгээнд авсан дээж бүрд хавсралтын дагуу дагалдах хуудас бөглөнө.
- Хөрснөөс шинжилгээнд авсан дээжийг бохирдол, урвалд орохооргүй цэвэр уут саванд хийж, хөрсний чийг, температурыг алдагдуулахааргүй хамгаалсан нөхцөлд тээвэрлэн хадгалж 24 цагийн дотор лабораторид хүргэж шинжилгээнд өгнө. Хэрэв дээрх хугацаанд хүргэх боломжгүй бол хөрөгчид (4-50C) хийж 3 хоногоос 1 сар хүртэл хугацаагаар хадгална.



Цаг уурын үзүүлэлтүүдийн нарийвчлалын
хамгийн бага шаардлага

№	Үзүүлэлт	Нэгж	Нарийвчлал
1	Агаарын даралт	гектоПаскаль (гПа)	1.0
2	Агаарын хэм	цельсийн градус (°C)	0.5
3	Салхины хурд	секунд дэх метр (м/с)	1.0
4	Салхины чиглэл	нумын өнцөг, зовхис/ градус, Ө, Х	
5	Нарны цацраг	квадрат метр дэх Ватт /Вт/м ² /	
6	Хур тунадас	миллиметр (мм)	
7	Ууршилт	миллиметр (мм)	
8	Агаарын чийгшил	Хувь (%)	
9	Үүлшил	балл (балл)	

Журмын хяналтын хуудас

Баримт бичгийн нэр	Байгаль орчны хяналт шинжилгээний журам
Баримт бичгийн код	ЭАР-БО-Ж02-И/18
Тодорхойлолт	Хүрээлэн буй орчны хяналт шинжилгээг явуулах үеийн зохион байгуулалт, харилцааг зохицуулна.
Анхны зохиогч	Ш.Намсрайжав, Г.Анх-Амгалан /Байгаль орчны мэргэжилтэн
Үүсгэсэн огноо	
Баталсан албан тушаалтан*	
Баталсан огноо*	

Нэмэлт өөрчлөлт

Хувилбар	Хянан засварласан огноо	Хянасан	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1				
2				
3				
4				

* Журам, горим, зааврын хамгийн эхний хувилбарыг баталж буй тохиолдолд бөглөнө.



АСГАРАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн хэмжээнд хаягдлын далан халих, шингэн хаягдлын хоолой задарсан тохиолдолд авах арга хэмжээг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журмыг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компани, тэдгээрийн туслан гүйцэтгэгч компанийн ажилтнууд дагаж мөрдөнө.

Хоёр. Асгаралтын мэдээлэл

- 2.1. Хаягдлын далан халих, шингэн хаягдлын хоолой задарч асгаралт гарсан тохиолдолд асгарсан хэмжээнээс үл хамааран тухайн ажилтан өөрийн шууд удирдлагад тэр даруйд мэдээлнэ.
- 2.2. Асгаралтыг мэдээлэх ажилтнуудын үүрэг оролцоог тус журмын нэгдүгээр хавсралтад оруулав.

Гурав. Хөрсний бохирдлыг тодорхойлох

- 3.1. Хаягдлын далан халих, сэдрэх, шингэн хаягдлын хоолой задарч асгаралт үүссэн газраас дамжин экосистем, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байвал мэргэжлийн байгууллагаар бохирдлыг тодорхойлуулж дүгнэлт гаргуулна.
- 3.2. Хаягдлын далан халих, сэдрэх, шингэн хаягдлын хоолой задарч асгаралт үүсгэсэн байгууллага нь хөрсний бохирдлыг тодорхойлох ажлын хөлсийг үл маргах журмаар гаргана.
- 3.3. Хөрсний бохирдлыг тодорхойлуулах зорилгоор мэргэжлийн байгууллагатай урт хугацааны гэрээг байгуулсан байна.

Дөрөв. Асгаралт болсон талбайг цэвэрлэх

- 3.4. Хаягдлын далан халих, сэдрэх, шингэн хаягдлын хоолой задарч асгаралт экосистем, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байвал 1 цагийн дотор асгаралтыг хяналтад авах, цэвэрлэх, хаягдлыг саармагжуулах арга хэмжээ авах үүрэгтэй.
- 3.5. Аливаа байгууллага нь асгаралтыг удирдах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бэлтгэлийг хангасан байна (Асгаралтыг удирдах хэрэгсэл хавсралт №2)
- 3.6. Асгаралтын цэвэрлэгээгээр үүссэн хог хаягдал аюултай хог хаягдалд тооцогдох ба Хог хаягдлын журам (ЭАР-БО-Ж08-И/18)-н дагуу тусгай зөвшөөрөлтэй байгууллагад шилжүүлнэ.
- 3.7. Хаягдлын далан халих, сэдрэх, шингэн хаягдлын хоолой задарч ноцтой аюултай хэмжээнд байвал яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- 3.8. Хаягдлын далан халих, сэдрэх, шингэн хаягдлын хоолой задарч бохирдсон хөрсийг саармагжуулахдаа бохир хөрс саармагжуулах талбайг ашиглана (Бохир хөрс саармагжуулах талбайд тавигдах шаардлага хавсралт №3).
- 3.9. Тусгай мэргэжлийн байгууллагаас тогтоосон байгууламж хэрэгслийн стандарт, асгаралтыг удирдах аргачлалыг баримтална.

Тав. Бүртгэл болон тайлагнах

- 4.1. “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн асгаралт гарсан тохиолдол, шалтгаан, авсан хариу арга хэмжээ зэргийг бүртгэлжүүлж нэгдсэн бүртгэл хөтлөн сар улирлын мэдээнд оруулна.
- 4.2. Асгаралтын мэдээг тухайн өдрийн диспетчерийн мэдээнд оруулна.

Зургаа. Сургалт

- 5.1. Ажилтан хаягдлын далан халих, сэдрэх, шингэн хаягдлын хоолой задарч асгаралт үүсэхэд хариу арга хэмжээ авах чадварыг сургалтаар эзэмшсэн байна.
- 5.2. Сургалтыг тусгай мэргэжлийн байгууллагаас жилд нэг удаа авч өмнөх жилүүдийн тохиолдол, туршлагад үндэслэн сургалтын агуулгыг шинэчилнэ.
- 5.3. Байгаль орчны мэргэжилтэн асгаралтыг удирдахтай холбоотой зөвлөгөө өгнө.

Долоо. Хариуцлага

- 6.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.
- 6.2. Гэрээт компанийн ажилтнуудын хувьд энэ журмыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох үндэслэл болно.



Асгаралтыг мэдээлэхэд ажилтнуудын үүрэг, оролцоо

№	Албан тушаал	Байгууллага	Үүрэг, хариуцлага, эрх
1	Байгаль орчны мэргэжилтэн	“Эрдэнэс алт ресурс” ХХК	✓ Асгаралтыг удирдахад мэргэжлийн зөвлөгөө өгч тусламж үзүүлэх
2	Нийт ажилтан	“Эрдэнэс алт ресурс” ХХК болон гэрээт байгууллага	✓ Асгаралтын талаар ойлголцтой байхыг шаардах, асгаралтыг удирдах чадвар эзэмших ✓ Асгаралт гарсан даруй байгаль орчны асуудал хариуцсан ажилтанд нэн даруй мэдэгдэх
3	Хэлтэс, нэгжийн удирдах ажилтан, томилогдсон мэргэжилтэн	“Эрдэнэс алт ресурс” ХХК, Гэрээт байгууллага	✓ Ажилтнууд асгаралтын удирдлагын талаар сургалтад хамрагдсан байхыг шалган баталгаажуулах
5	Гэрээт байгууллагын байгаль орчны мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн	Гэрээт байгууллагууд	✓ Нийт ажилчдад асгаралтыг удирдах чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах ✓ Асгаралтын урьдчилсан мэдээг 4 цагийн дотор бэлтгэн “Эрдэнэс алт ресурс” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэнд хүргүүлэх /Хавсралт №4/ ✓ Асгаралтын шалтгаан, асгарсан хэмжээ, бохирдсон хөрсний хэмжээг тодорхой болгох, бохирдсон хөрсийг цэвэрлэж хариу арга хэмжээ авсны дараа Асгаралтын тайланг хүргүүлэх /Хавсралт №5/

Асгаралтыг удирдах хэрэгсэл



№	Бүрэлдэхүүн	Хэмжээ	Шаардлага
1	Ашиглах заавар	1 ш	Монгол хэл дээр, асгаралтын иж бүрдлийг ашиглах бүрэн заавар оруулсан байх.
2	Гар хамгаалах бээлий	2 ш	Материал: Химийн бодист тэсвэртэй, зузаан, резин
3	Ковш	1 ш	Асгарсан шингэн хаягдлыг тээвэрлэх
4	Шуудай	80 ш	1 кг савлагаатай
5	Сав	1 ш	240л багтаамжтай, Дугуйтай, түрж явах боломжтой, бохирдсон материал хийх даац сайтай зориулалтын хогийн сав
6	1 удаагийн комбинезон	20 ш	1 удаа хэрэглэдэг, материал сайтай
7	Хүрз	20 ш	Шингэн хаягдлыг зайлуулахад ашиглана
8	Усны насос	2 ш	Их хэмжээний шингэн хаягдал асгарсан тохиолдолд ашиглана.



Бохирдсон хөрс саармагжуулах талбайд тавигдах шаардлага

№	Төлөвлөлт	Хийгдэх ажил
1	Бохирдсон хөрс саармагжуулах талбайн байршил, хэмжээг тодорхой болгох	Уурхайн төлөвлөлтийн инженерүүдтэй хамтран маркшейдерийн хэмжилт хийж, акт үйлдэх
2	Бохирдсон хөрс саармагжуулах ажлыг зохион байгуулах	Уурхайн ажилчид нэн даруй арга хэмжээ авч ажиллах
4	Шаардлагатай хөрсөөр хучих талбайг	Талбайг хөрсөөр хучиж дэвсэлт хийх, бохирдсон хөрсний талбайн ирмэгээр 20 см-с багагүй хөмсөг тавих

АСГАРАЛТЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ				№			
Огноо:		Цаг:		Мэдээлсэн ажилтан:			
Албан тушаал/		Утас:		Ээлж:	☐	Өдөр	☐
Байршил:			☐			☐	
Тоног төхөөрөмжийн төрөл:				Тоног төхөөрөмжийн ID:			
Асгаралт үүсэх хүртэлх үйл явц:							
Асгарсан бүтээгдэхүүн:	☒	Хэмжээ (л, тн):		Асгарсан бүтээгдэхүүн:	☒	Хэмжээ (л, тн):	
Гидрийн шингэн	☐			Хөргөлтийн шингэн	☐		
Дизель түлш	☐			Бохир ус	☐		
Шингэрүүлсэн хий	☐			Гликол	☐		
Кропны тос	☐			Хүч дамжуулах шингэн	☐		
Бусад тос, тосолгоо	☐			Бусад	☐		
Асгаралт үүссэн шалтгаан:		Тайлбар					
Шингэнийг хэт дүүргэсэн							
Техникийг зүй бус ашигласан							
Буруу техник ашигласан							
Сургалт хангалтгүй							
Жийргэвч сэтэрсэн							
АА-н системийн алдаа							
Дамжуулах хоолой задарсан							
Бусад							
Мэдээлэх хуудас бөглөсөн ажилтны овог нэр:							
Албан тушаал:		Гарын үсэг:		Огноо:			

**ALT RESOURCE
LLC**

Туслах үйлчилгээгч
6289754 ᠘ СБТ11352
УЛААНБААТАР ХОТ
КОМПАНИЙН
НӨР, ДУГААР

Асгаралт хязгаарласан байдал (холоос)		Асгаралт хязгаарласан байдал (ойроос)	
Саармагжуулсан байдал (холоос)		Саармагжуулсан байдал (ойроос)	
Асгаралтын эсрэг авсан арга хэмжээ:			
Тайлан хуудас бөглөсөн ажилтны овог нэр:			
Албан тушаал:		Гарын үсэг:	Огноо:

Журмын хяналтын хуудас

Баримт бичгийн нэр	Асгаралтын журам
Баримт бичгийн код	ЭАР-БО-Ж03-И/18
Тодорхойлолт	Хаягдлын далан халих, шингэн хаягдлын хоолой задарч асгарсан тохиолдолд авах арга хэмжээг зохицуулна.
Анхны зохиогч	Ш.Намсрайжав, Г.Анх-Амгалан /Байгаль орчны мэргэжилтэн/
Үүсгэсэн огноо	
Баталсан албан тушаалтан*	
Баталсан огноо*	

Нэмэлт өөрчлөлт

Хувилбар	Хянан засварласан огноо	Хянасан	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1				

* Журам, горим, зааврын хамгийн эхний хувилбарыг баталж буй тохиолдолд бөглөнө.



НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн хэмжээнд уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн бүх хэсэг, нэгж болон гэрээт компани, тэдгээрийн ажилтнуудад нэгэн адил хамаарна.
- 1.3. Энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг холбогдох дүрэм, журам, ажлын горим, зааврын дагуу шийдвэрлэнэ.
- 1.4. “Нөхөн сэргээлт” гэж Уурхайн олборлолтын үйл ажиллагаа болон, уурхайлалт явагдаж байх хугацаанд, эсхүл уурхай хаагдсаны дараа тухайн газар нутгийг хуучин дүр төрхөд нь оруулах болон, ойртуулах арга хэмжээг;

Хоёр. Нөхөн сэргээлт хийх шаардлага, суурь нөхцөл

- 2.1. Нөхөн сэргээх талбай нь уурхай хаагдах хүртэлх хугацаанд уурхайн үйл ажиллагааны зориулалтаар ашиглагдахгүй бол нөхөн сэргээх боломжтой гэж үзнэ.
- 2.2. Нөхөн сэргээх талбайн байршлыг хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, ТЭЗҮ, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын зөвшилцөлд үндэслэн тодорхойлно.
- 2.3. Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад эвдэрсэн нөхөн сэргээх шаардлагатай газрын цаашид ашиглах хэлбэрийг тодорхойлох, нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнтэй явуулах суурь нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой судалгаа хийх. Үүнд:
 - а. Орчны нөхцөлийн суурь судалгаа хийх.
 - б. Нөхөн сэргээлт хийгдэж буй бүс нутагт явагдах өндөр магадлалтай технологийн үйл ажиллагааг судлан тогтоож нөлөөллийн хүчин зүйл харгалзаж үзэх.
 - в. Хөрсний өгөршил явагдах зүй тогтлыг тогтоох зорилгоор геохимийн судалгаа хийх.
 - г. Хүчлийн урсцын үүсгэгч хүчин зүйлийг судлах.
 - д. Геотехник, тогтворжилтын судалгаа хийх.
 - е. Талбайг ашиглах чиглэлийг харгалзан үзэж ойрын болон хэтийн төлөвийг тодорхойлох.
 - ж. 8-с багагүй жилийн хугацаанд байгалийн болон техноген нөлөөгөөр хувьсаж тогтвортой байдалд хэрхэн өөрчлөгдөх талаар симуляци хийх.

Гурав. Нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө

- 3.1. Нөхөн сэргээлт хийх талбайн байршил болон ажил гүйцэтгэхээс өмнө тухайн газрын эвдрэлийн хэмжээг тодорхойлох, шаардлагатай баримтжуулалт хийнэ.
- 3.2. Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, түүнд шаардагдах зардлыг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд заавал тусган хэрэгжүүлнэ.
- 3.3. Нөхөн сэргээлтийн ажлын календарчилсан төлөвлөгөө гарган жил бүр хэрэгжүүлнэ.
- 3.4. Нөхөн сэргээх үйл ажиллагаа нь тухайн газрын гадаргуугийн бүтэц болон хөрс, гидрологийн удаан хугацааны тогтвортой байдлыг хангасан байвал зохино.

Дөрөв. Техникийн нөхөн сэргээлт хийх

- 4.1. Техникийн нөхөн сэргээлт гэдгийг дараах утгаар ойлгоно. Үүнд: Тухайн үйлдвэрлэл, олборлолтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх анхан шатны үйл ажиллагааг хэлнэ. Уг үйл ажиллагаа нь биологийн нөхөн сэргээлт хийх үндэс суурь болно.
- 4.2. Тухайн жилийн уулын болон, хайгуулын ажлын төлөвлөгөөтэй уялдан нөхөн сэргээх төлөвлөгөөт ажил хийгдэнэ. Нөхөн сэргээх талбай гэдэгт гадаад болон дотоод овоолго, уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар, тээврийн шороон зам зэргийг хамруулан ойлгоно.
- 4.3. Нөхөн сэргээхээр төлөвлөсөн талбайн тооцоо, судалгааг тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан гаргана.
- 4.4. Тухайн талбайд ажил эхлэхээс өмнө гадаргууг сийрүүлэн тэгшлэх, хэлбэржүүлэх, гадаргуугийн хэлбэр төрхтэй ойртуулан дэнжлүүлэн өндөрлөх, оройг нь намсгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэх.
- 4.5. Нөхөн сэргээх ажлыг хийж эхлэхээс өмнө эхлээд хөрсөөр дараа нь шимт хөрсөөр хучаас хийвэл зохино.
- 4.6. Шимт хөрсөөр хучилт хийхийн өмнө тухайн талбай дахь овор ихтэй чулуулаг, хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- 4.7. Нөхөн сэргээлтийн ажилд хосолсон чиглэлийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг баримтлал болгон ажиллах бөгөөд, технологийн бүдүүвчийг боловсруулсан байх шаардлагатай.

Тав. Эвдэрсэн газар нөхөн сэргээх

- 5.1. Тухайн талбай дээрх эвдэрсэн газрын хэмжээг тооцон гаргах, шаардагдах хэмжилт болон, ажлын хэмжээг тооцно.
- 5.2. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулж, эвдэрсэн газар болон ажил гүйцэтгэх талбайн зураглалыг гаргана.
- 5.3. Тус ажилд техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа холбогдох журам, стандартын дагуу шимт хөрсөөр хучих эсэхийг шийдвэрлэнэ.
- 5.4. Хийгдэх шаардлагатай ажлыг тодорхойлж, байршлаас хамааруулан тухайн ажил хийгдэж дууссаны дараа шаардлагатай тохиолдолд, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн сум орон нутгийн холбогдох шатны албан тушаалтанд хүлээлгэн өгч акт үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна.
- 5.5. MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал, MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, хаалтын менежментийн жишиг төлөвлөгөө, MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага, MNS 5918:2008 Эвдэрсэн газрын ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага, шимт хөрс хуулах зөвшөөрлийн хуудас зэрэг холбогдох стандарт, хууль, тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

Зургаа. Хайгуулын ажлын цооногийн нөхөн сэргээлт

- 6.1. Тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу хийгдсэн цооногийг төлөвлөгөөт хугацаанд нөхөн сэргээх шаардлагатай.
- 6.2. Нөхөн сэргээх ажлыг ажил гүйцэтгэгч гэрээт компани хэрэгжүүлэх бөгөөд, гэрээт хугацаанд “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн, геологич, маркшейдер, төлөвлөлтийн инженерүүд хяналт тавьж ажиллана.
- 6.3. Тухайн ажил хийгдэж дууссаны дараа, гүйцэтгэгч компанийн гэрээ дуусахаас өмнө, нөхөн сэргээсэн талбайг гэрээт компанийн холбогдох ажилтан, “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн геологич, байгаль орчны мэргэжилтнүүд хамтран хүлээлцэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 6.4. Нөхөн сэргээлт хангалттай сайн болсон гэж үзвэл талууд дараагийн шатны арга хэмжээ буюу, шаардлагатай тохиолдолд сум орон нутагт хүлээлгэн ажлыг шуурхай зохион байгуулна.

- 6.5. Сум орон нутагт хүлээлгэн өгөх ажилд “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн геологич болон байгаль орчны мэргэжилтэн, гэрээт компанийн холбогдох албан тушаалтан хамтран оролцож хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулна.

Долоо. Биологийн нөхөн сэргээлт хийх

- 7.1. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссаны дараах үе шатыг биологийн нөхөн сэргээлт гэх бөгөөд, уурхайн олборлолтын үйл ажиллагаа хийгдэж дууссаны дараа, дахин уурхайн үйл ажиллагаанд өртөхөөргүй болсон хэсэгт хийгдэх үйл ажиллагааг ойлгоно.
- 7.2. Тухайн газрын хөрс нь биологийн нөхөн сэргээлт хийхэд тохиромжгүй байвал хөрсний физик-химийн шинж чанарыг сайруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 7.3. Нөхөн сэргээлтэд тохирохгүй хурдас чулуулгийг шаталсан арга хэмжээний дараа шимт хөрсөөр хучих ажлыг хийж гүйцэтгэнэ. Шимт хөрсөөр хучих эсэхийг /Шимт хөрстэй ажиллах журмаар/ зохицуулна.
- 7.4. Биологийн нөхөн сэргээлтийг хийхдээ бүс нутгийн онцлогт тохирсон арга ажиллагааг мөрдлөг болгохоос гадна, тухайн газрын үржил шимийн түвшин буюу ялзмагийн хэмжээ, хүчиллэг болон шүлтлэг шинж чанарын талаарх судалгааг үндэслэх шаардлагатай.
- 7.5. Биологийн нөхөн сэргээлтийг хийхдээ дараах зүйлийг анхаарах шаардлагатай.
- а. Тухайн орчны хөрсний шинж чанарыг тодорхойлох
 - б. Хөрсний хэв шинжийг тодорхойлох
 - в. Хөрсний үржил шимийг сайжруулах шаардлагатай бол сайжруулах шаардлагыг тодорхойлох
 - г. Техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа тухайн талбайн нөхцөл байдлыг харгалзан, шимт хөрсийг дараах харьцаагаар хучилт хийнэ.
 - Дан шимт хөрсөөр 5-30 см зузаантай хучих
 - Шимэрхэг хөрсөөр 20-30 см зузаантай хучиж, дээр нь шимт хөрсөөр 5-20 см зузаантайгаар хучих
 - Шимт ба шимэрхэг хөрсний 50:50 харьцаатай хольцоор 5-30 см зузаантай хучих
 - Дан шимэрхэг хөрсөөр 10-30 см хучих зэрэг хувилбаруудаас тухайн нөхцөлд тохируулан сонгож хэрэглэх боломжтой. /Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал/
 - д. Тухайн ажлыг хийж гүйцэтгэхээс өмнө шимт хөрсний үндсэн үзүүлэлтүүд “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5916:2008” стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг тогтооно.
 - е. Хими-физикийн шинж чанараараа биологийн нөхөн сэргээлтэд тохиромжгүй чулуулгийн дээгүүр шимт хөрсний үе давхаргаар шууд хучиж болохгүй. /Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал/
 - ж. Нөхөн сэргээлтийн ажил нь шимт хөрс хуулах, хуулсан хөрснөөс хамаар ч уялдан холбогдож Шимт хөрс хуулах журам, маягтын дагуу хуулагдсан чанартай хөрсөөр нөхөн сэргээлт хийгдэнэ.

Найм. Хариуцлага

- 8.1. Техникийн нөхөн сэргээлт:
- а. Байршил болон, тухайн талбайн хэмжээ байршлын зургийг уул хариуцсан нэгж гаргах бөгөөд, байгаль орчны мэргэжилтэн хамтран оролцоно.
 - б. Тухайн ажилд шаардлагатай техник тоног төхөөрөмжийн гүйцэтгэх ажил, шаардагдах хугацааг уул хариуцсан нэгж гаргана.

- в. Ажлын гүйцэтгэлд уулын мастер болон байгаль орчны мэргэжилтэн хяналт тавина.
 - г. Нөхөн сэргээлтийн ажил эхлэхээс өмнө байгаль орчны мэргэжилтэн тухайн цэгээс дээжлэлт хийж шинжилгээнд хамруулах бөгөөд, гэрээт туслан гүйцэтгэгч компанийн байгаль орчны мэргэжилтнүүд хамтран оролцоно.
 - д. Уул хариуцсан нэгж тухайн жилийн уул хариуцсан нэгжийн төлөвлөгөөнд тусган, төлөвлөгөөт хугацаанд хийгдэх ажлыг тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - е. Төлөвлөсөн хугацаанд ажил хийгдэж дууссаны дараа байгаль орчны мэргэжилтэн болон уулын мастер нар хянах бөгөөд шаардлага хангасан нөхцөлд дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 8.2. Биологийн нөхөн сэргээлт:
- а. Биологийн нөхөн сэргээлтийн үндсэн зорилго нь байгалийн аясаар ургамал ургах явцыг хурдасгах, ургалтыг дэмжих бичил уур амьсгал бүрдүүлэхэд оршино.
 - б. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж тухайн газар биологийн нөхөн сэргээлт хийх шаардлага хангасны дараа байгаль орчны мэргэжилтнүүд дараагийн шатны төлөвлөгөөний арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
 - в. Авч хэрэгжүүлэх арга хэмжээнд тухайн талбайд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөлтөөс гадна, тариалах олон наст ургамлын норм нормативыг тусгасан байх бөгөөд “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн болон туслан гүйцэтгэгч компанийн байгаль орчны мэргэжилтнүүд нөхөн сэргээлтийн арга хэмжээнд хамтран оролцоно.
 - г. Тухайн жил нөхөн сэргээх талбайн төлөвлөгөөг урьдчилж ярилцан, уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулах ажлыг байгаль орчны мэргэжилтнүүд болон, төлөвлөлтийн инженер хамтран гүйцэтгэнэ.
- 8.3. Байгаль орчны мэргэжилтэн шимт хөрсийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавина.
- 8.4. Нөхөн сэргээлт, бүтээн байгуулалт хариуцсан байгаль орчны мэргэжилтэн шимт хөрс хамгаалах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, шимт хөрс хамгаалахад шаардлагатай тоног төхөөрөмж, тарих үрийн судалгааг хийж, захиалж бэлэн байлгана.
- 8.5. Төлөвлөлтийн инженер нь тухайн жилийн уулын ажлын төлөвлөлтөд шимт хөрсний хэмжээ, шимт хөрсний овоолго үүсгэх талбай, хуулалт хийгдэх хуваарийг гаргах, шимт хөрсний байршлын зураг боловсруулах, техникийн паспорт үйлддэг байх;
- 8.6. Уулын мастер нь шимт хөрс хуулах, овоолго үүсгэх, хэлбэржүүлэлт хийх ажилд хяналт тавих;
- 8.7. Гэрээт туслан гүйцэтгэгч компанийн байгаль орчны мэргэжилтэн нь шимт хөрсний хуулалт, овоолгын байдал, нөөц болон чанарт байнгын хяналт явуулах, баримтжуулалт хийх, шимт хөрсний чанарыг доройтуулах үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээлтээс өөр зориулалтаар ашиглах, зөвшөөрөлгүй шимт хөрс хуулах, газар ашиглах эрсдэлээс сэргийлэх
- 8.8. Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ, Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

Долоо. Бүртгэл, тайлан

- 9.1. Байгаль орчны мэргэжилтнүүд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн газрын мэдээллийг баримтжуулж, бүртгэлжүүлэн, мэдээллийн сан үүсгэн хадгална.
- 9.2. Үүсгэсэн мэдээллийн санд хайгуулын ажлын цооногийн нөхөн сэргээлт, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт зэрэг багтана.
- 9.3. Мэдээллийн санг жил бүр шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.

9.4. Шаардлагатай зураг, мэдээллийн баазыг үүсгэх ажлыг уул хариуцсан нэгжтэй хамтран гүйцэтгэнэ.

Журмын хяналтын хуудас

Баримт бичгийн нэр	Нөхөн сэргээлтийн журам
Баримт бичгийн код	ЭАР-БО-Ж04-И/18
Тодорхойлолт	Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
Анхны зохиогч	Ш.Намсрайжав, Г.Анх-Амгалан /Байгаль орчны мэргэжилтэн/
Үүсгэсэн огноо	
Баталсан албан тушаалтан*	
Баталсан огноо*	

Нэмэлт өөрчлөлт

Хувилбар	Хянан засварласан огноо	Хянасан	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1				
2				
3				
4				

* Журам, горим, зааврын хамгийн эхний хувилбарыг баталж буй тохиолдолд бөглөнө.

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн Гүйцэтгэх
захирлын үүрэг гүйцэтгэлийн 2024 оны 04
сарын 23-ний өдрийн А/13 дугаар
тушаалын тавдугаар хавсралт



ХУДАГ, УСТ ЦЭГТ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Зорилго, хамрах хүрээ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь худгийн ус бохирдохоос сэргийлэх, эрүүл ахуйн дэглэмийг мөрдөн ажиллах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх үед засвар үйлчилгээ хийх, хүйтний улиралд хөлдөхөөс сэргийлэн байр барих, ундарга багассан худагт шавхалт хийж, ундаргыг сэргээн лайдах, худгийн амны засвар үйлчилгээг хийх ажлын харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журмыг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн хэлтэс, нэгжүүд, гэрээт компанийн ажилтнууд нэгэн адил дагаж мөрдөнө.

Хоёр. Ерөнхий шаардлага

- 2.1. Худгийн байр барих, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх, малчдын худгийн ам сэргээн засах ажлыг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн болон гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтнүүд нь мужаан, сантехникч, цахилгаанчин нарын оролцоотойгоор хийж гүйцэтгэнэ.
- 2.2. Худаг лайдах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ.
- 2.3. Засвар үйлчилгээ хийхийн өмнө худгийн тоноглолыг судалж ямар тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглахыг урьдчилан тооцоолж бэлтгэсэн байх бөгөөд дээрх ажлыг гүйцэтгэх ажилтнууд нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.
- 2.4. Худгийн байр барьж байгуулсан, засвар үйлчилгээ хийсэн, лайдсан, амыг сэргээн засварласан тухай тус бүрийн актыг үйлдсэнээр ажил дуусгавар болох ба актад байгаль орчны мэргэжилтэн, механик, гидрогеологич, сантехникч, цахилгаанчин, байгаль орчны улсын байцаагч зэрэг холбогдох хүмүүс гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Худгийн байранд тавигдах шаардлага, хяналт

- 3.1. Худгийн байрыг сэндвичен хавтан эсвэл блокоор барих ба суурийг цементээр цутгаж, бат бөх байдлыг хангана.
- 3.2. Худгийн байр нь 4х4 м хэмжээтэй, 3.5 м өндөртэй байна.
- 3.3. Хаалгыг төмөр материалаар хийх ба цүү цоожтой байна.
- 3.4. Харуултай худгийг агааржуулах цонхтой хийх ба цонхны хэмжээ нь 1 м өндөр, 0.7 м өргөнтэй байна.
- 3.5. Харуулгүй худгийн байранд цонх хийх шаардлагагүй.
- 3.6. Худгийн байрны цахилгаан үүсгүүр, гэрэлтүүлгийг бүрэн шийдвэрлэсэн байна.

Дөрөв. Цооногийн тоноглолд засвар үйлчилгээ хийх шаардлага

- 4.1. Цооногийн тоноглолд шүүр, яндан, хэвтээ, босоо хоолой, ус өргөгч буюу насос, тоолуур, усны дээж авах крант зэргийг хамруулна.
- 4.2. Цахилгааны утасны гэмтэл, тоолуур, насос, шүүр, хоолой, крант, шахуургын эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг хийнэ.
- 4.3. Цооногт усны автомат түвшин хэмжигч (levellogger) суурилуулах ба хоолойн өргөн 40 мм-н диаметртэй байна.
- 4.4. Шинээр суурилуулах усны тоолуур нь үйлдвэрийн гарал үүслийн бичигтэй, ашиглалтын заавартай байна. Гүний худгийн усны тоолуур болон анхдагч мэдрэгчүүдийг Стандарт хэмжил зүйн газарт шалгуулж, баталгаажуулсан байх ба шалгаж туршсан акт, гэрчилгээтэй байна.

- 4.5. Худгийн усны тоолуур эвдэрсэн тохиолдолд тоолуурыг авч салгах, засварлан буцааж тавих, шинээр тоолуур суурилуулахдаа лацдуулах, баталгаажуулах ажлыг байгаль орчны улсын байцаагчийн хяналтын доор хийж гүйцэтгэнэ.
- 4.6. Худгийн шахуургыг гаргахын өмнө дээврийн хавтанг гэмтээлгүй салган авч ажил дууссаны дараа буцаан угсарч хэвийн байдалд нь оруулна. Худгийн сантехникийн холболтуудыг салгаж, краны тусламжтай шахуургыг ус өргөх хоолойн хамт гаргана.
- 4.7. Шүүрийн янданг цэвэрлэхдээ худгийн нөхцөл байдлаас хамаарч цэвэрлэгээний тохирох аргыг хэрэглэнэ.
- 4.8. Хайрган чигжээсийг нягтруулах, цооногт орох усны урсгалын хэмжээг дээшлүүлэх, уст үеийн гидравлик холбоог сайжруулах, цооногт суулгах ус өргөх төхөөрөмж /насос/-ийн хүчин чадлыг сонгох зорилгоор цооногийн ундаргыг тодорхойлно.
- 4.9. Шахуургыг суулгасны дараа хэвийн ажиллаж эхлэх хүртэл, мөн ус тунгалаг болсон тохиолдолд худгийн ундаргыг тодорхойлно.
- 4.10. Цахилгааны утас шалбарч гэмтсэн тохиолдолд утсыг солих, засаж сэлбэх ажлыг цахилгаанчнаар гүйцэтгүүлнэ.
- 4.11. Хүйтний улиралд худгийн тоолуур, насос хөлдөхөөс сэргийлсэн халаагуур байрлуулна.
- 4.12. Худгийн байр доторх босоо хоолойноос усны дээж авах зориулалт бүхий жижиг крантыг гаргасан байна.

Тав. Худгийн ундаргыг сэргээх, лайдах

- 5.1. Худгийн усны урсгалын хэмжээг дээшлүүлэх, уст үеийн гидравлик холбоог сайжруулах, цооногийн ундаргыг тодорхойлох шавхалтыг 4-8 цагийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 5.2. Шавхалт хийж байх үедээ худгийн усны ундаргыг халиагуурын аргаар хэмжих ба шавхалтын үеийн журнал хөтөлнө.
- 5.3. Худгийн уснаас дээж авч усны химийн бүрэн шинжилгээнд хамруулах ба шинжилгээний дүнг эх хувиар нь актад хавсаргана. Дээжлэлтийн зорилго нь худгийн усны бохирдлыг тодорхойлж ундны усны MNS0900:2018, MNS6148:2010 стандартад нийцэж байгааг тодорхойлох юм.
- 5.4. Үр дүнд хүрээгүй байвал дээрх ажилбарыг давтан хийнэ.
- 5.5. Худгийн тохижилт, битүүмжлэл, ашиглалт, ариун цэврийн байдлын тухай тодорхойлж, фото зураг зэргийг оруулсан товч тайлан боловсруулна.

Зургаа. Худгийн ам сэргээн засварлах, онгоц байрлуулах

- 6.1. Гадаргын урсац болон хог хаягдал худагт орох, мал амьтан унахаас сэргийлж худгийн амыг өндөрлөж хамгаалсан ам таглаа бүхий худаг бий болгоход MNS 6279:2011 стандартыг мөрдлөг болгоно.
- 6.2. Худгийн амны эвдэрч, нурсан хэсгийг худаг руу оруулахгүйгээр цэвэрлэж авна.
- 6.3. Амыг сэргээхдээ тухайн худгийн амны өндрөөс 20 см-ээс ихгүй байхаар өндөрлөх ба цементээр цутгаж, бат бөх байдлыг хангана. Худгийн амны амсар нь усны ховоо чөлөөтэй орж гардаг байхаар тохируулан хийнэ.
- 6.4. Худгийн тагийг мод эсвэл төмрөөр худгийн амсарт тохируулж хийнэ.
- 6.5. Олон малтай малчдын усалгаа хүлээх цагийг богино болгохын тулд онгоцыг малын тоонд тохируулан аль болох олон мал зэрэг ус уух боломжтой хэмжээгээр төлөвлөнө.
- 6.6. Онгоц нь төмөр материалаар хийгдсэн байх бөгөөд түүнийг зөөж байршуулах, байрлалыг өөрчлөхөд төвөг учруулахгүй байхаар төлөвлөнө. Онгоцны урт 3 м,

өргөн 50 см-ээс доошгүй, газрын гадаргаас дээш 40 см-ээс багагүй зайд байрлуулна.

- 6.7 Онгоцны ирмэгийг малын эрүү ам урахгүй, гэмтээхгүй (ирмэгт катанг гагнах), 2 талаасаа ус уухад толгой тулахгүй байхаар төлөвлөж хийнэ.
- 6.8 Онгоцыг худгаас тал тал тийш цацраг хэлбэрээр байрлуулах, 2-оос доошгүй онгоц байрлуулах зэргээр богино хугацаанд мал усалж дуусах боломжтой байдлаар төлөвлөж хийнэ.

Долоо. Худгийг тэмдэгжүүлэх

- 7.1. Самбарыг төмөр материалаар, өнгө үзэмжтэй хийх ба ЭАР ХХК-ийн логог дээд талд голлуулан байрлуулна.
- 7.2. 50 м зайнаас худгийн дугаар харагдахуйц байхаар хийх ба самбар, үсгийн фондын хэмжээг дараах байдлаар хийнэ.
- 7.3. Уурхайн худгуудад байрлуулах самбарын урт 50 см, өргөн 35 см байх бол "Худаг №" гэсэн таних тэмдгийн өндөр 25 см, өргөн 15 см хэмжээтэй байна. Бусад бичвэрийн өндөр 10 см, өргөн 3 см өргөнтэй байна. Самбарыг худгийн байрны гадна талын хананд бат бөх суурилуулна (Хавсралт 4).
- 7.4. Малчдын худгуудад байрлуулах самбарын урт 35 см, 25 см, том бичвэрийн өндөр 20 см, өргөн 10 см хэмжээтэй байна. Самбарыг төмөр хөлтэй хийж, цементээр цутган мал амьтан шүргэж унагахгүйгээр бат бөх суурилуулна (Хавсралт 5).

Найм. Уурхайн худгуудын хяналт

- 8.1 Худгийн насос, тоолуур цахилгаан үүсгүүрийн хэвийн ажиллагааг тогтмол хугацаанд шалгаж байна.
- 8.2 Тээврийн хэрэгслийн жолооч нь гүний худгаас ус авах явцдаа тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл илэрсэн даруйд "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэнд нэн даруй утсаар мэдэгдэж дуудлага өгнө.
- 8.3 Байгаль орчны мэргэжилтэн мэдээллийг авсан даруйд холбогдох хүмүүсийг оролцуулан засвар үйлчилгээний ажлыг гүйцэтгэнэ.
- 8.4 Усан сан, худгуудын тоолуурыг заалтад байгаль орчны мэргэжилтэн хяналт тавина.

Ес. Хариуцлага

- 9.1. Энэ горимыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

Худаг, уст цэгт засвар үйлчилгээ хийх
журмын нэгдүгээр хавсралт



ХУДГИЙН БАЙР БАРЬЖ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ АКТ

Байгууллагын нэр:

Худгийн байршил, дугаар:

Ашиглалтад орсон огноо:

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

№	Овог нэр	Албан тушаал	Хариуцаж гүйцэтгэсэн ажлын хуваарь
1			
2			
3			
4			
5			

Хийсэн ажлын талаарх товч тэмдэглэл (ажил гүйцэтгэсэн хугацаа, хийгдсэн ажил):

.....
.....
.....
.....
.....

Акт үйлдсэн албан тушаалтан: /Овог нэр, албан тушаал/

Актыг хүлээн авсан албан тушаалтан: /Овог нэр, албан тушаал/

Жич: Ажлын тайланг хавсаргана.

Худаг, уст цэгт засвар үйлчилгээ хийх
журмын хоёрдугаар хавсралт



ХУДАГ, УСАН САН ЛАЙДАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ТУХАЙ АКТ

Байгууллагын нэр:

Худгийн байршил, нэр:

Ашиглалтад орсон огноо:

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

№	Овог нэр	Албан тушаал	Хариуцаж гүйцэтгэсэн ажлын хуваарь
1			
2			
3			
4			
5			

Ажил эхлэхийн өмнөх лабораторийн шинжилгээ хийсэн огноо:

(шинжилгээний дүнг хавсаргах)

Шавхалтын төрөл:

Шавхалт хийсэн хугацаа:

Ажил дууссаны дараа хийлгэсэн лабораторийн шинжилгээний дүн:

(шинжилгээний дүнг хавсаргах)

Акт үйлдсэн албан тушаалтан: /Овог нэр, албан
тушаал/

Актыг хүлээн авсан албан тушаалтан: /Овог нэр, албан тушаал/

Жич: Ажлын тайланг хавсаргана.

Худаг, уст цэгт засвар үйлчилгээ хийх
журмын нэгдүгээр хавсралт



ТООЛУУР ШИНЭЭР ТАВИХ БОЛОН СОЛЬЖ ТАВЬСАН ХИЙСЭН ТУХАЙ АКТ

Байгууллагын нэр:

Худгийн байршил, дугаар:

Ашиглалтад орсон огноо:

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

№	Овог нэр	Албан тушаал	Хариуцаж гүйцэтгэсэн ажлын хуваарь
1			
2			
3			
4			
5			

Хийсэн ажлын талаарх товч тэмдэглэл (ажил гүйцэтгэсэн хугацаа, хийгдсэн ажил):

.....
.....
.....
.....
.....

Акт үйлдсэн албан тушаалтан: /Овог нэр, албан
тушаал/

Актыг хүлээн авсан албан тушаалтан: /Овог нэр, албан тушаал/

Жич: Ажлын тайланг хавсаргана.

**ХУДГИЙН АМ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН
ТУХАЙ АКТ**

Байгууллагын нэр:.....
Худгийн байршил, нэр:
Худаг эзэмшигч:
Усалдаг малын тоо:

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

№	Овог нэр	Албан тушаал	Хариуцаж гүйцэтгэсэн ажлын хуваарь
1			
2			
3			
4			
5			

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

/Овог нэр/

АКТ ҮЙЛДСЭН:

УСНЫ ТЕХНИКЧ

/Овог нэр/

202... оны ... сарын ...

Жич: Ажлын тайланг хавсаргана.

**УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАДАГ ХУДАГ ТУС БҮРИЙН ГҮНИЙ
ТҮВШИН,
ЛИТР, СЕКУНДИЙН ТООЦООНЫ АКТ**

Тайлбар: 202.. оны .. дүгээрны өдөр 18 л саванд хэмжиж үзэв.

Худагны нэр	Тест	1 сек/л	1 мин/л	1 цаг/л	24 цаг/ м3	Худгийн түвшин /м/
1 дүгээр худаг	29.54	0.609	36.56	2193.6	52.6	86
2 дугаар худаг	Тасалдсан байдалтай байсан	-	-	-	-	
4 дүгээр усан сан						
4 дүгээр худаг	11.3	1.59	95.57	5734.5	137.6	
6 дугаар худаг	Шавхарсан	-	-	-	-	
7 дугаар худаг	4.6	3.9	234.7	14086.9	338.1	
8 дугаар худаг	Шавхарсан	-	-	-	-	
11 дүгээр худаг	Тоолуурын заалтаар л/сек үзсэн 5.2	3.4	207.6	12461.5	299.1	
12 дугаар худаг	Тоолуурын заалтаар л/сек үзсэн 10	1.8	108	6480	155.5	
Нийт 930.3						
5 дугаар усан сан						
3 дугаар худаг	Шавхарсан	-	-	-	-	
9 дүгээр худаг	9.8	1.8	110.2	6612.2	158.6	
10 дугаар худаг	7.43	2.4	145.3	8721.4	209.3	
5 дугаар худаг	Тасалдсан байдалтай байсан	-	-	-	-	
Нийт 370.6						
Уурхайн бүх худгыг ажлуулахад өдөрт гарах усны хэмжээ						

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

.....

ТООЦОО ГАРГАСАН:

САНТЕХНИКЧ, УСНЫ ТЕХНИКЧ

.....

202... оны ... сарын ...

ХУДГИЙН ТЭМДЭГЖҮҮЛЭЛТ /УУРХАЙН ХУДАГ/



Худаг:№

Худгийн эд зүйлсийг ариг гамтай ашиглацгаая.

ХУДГИЙН ТЭМДЭГЖҮҮЛЭЛТ /МАЛЧНЫ ХУДАГ/



Энэхүү худгийг ХХК-ийн хөрөнгөөр сэргээн засварлав.

Багийн нэр:
Худгийн нэр:
Координат:



ГАЗАР ХӨНДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн эзэмшлийн уурхайн бүсэд хийгдэх аливаа газар хөндөх ажлыг төлөвлөж, гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журмыг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компани, тэдгээрийн туслан гүйцэтгэгч компанийн ажилтнууд дагаж мөрдөнө.
- 1.3. Энэ журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль болон бусад журам, горим, заавраар зохицуулна.
- 1.4. Уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хүн-техникийн хүчээр хийгдэх газар шорооны ажил болох шимт хөрс хуулах, суваг шуудуу татах, малталт хийх, цооног өрөмдөх, хашаа, барилга барих, тоног төхөөрөмж суурилуулах зэрэг ажил нь газар хөндөх ажиллагааны үндсэн дээр хийгддэг тул тусгай төлөвлөгөөтэй байна.
- 1.5. Бүх төрлийн цахилгааны болон утасны сүлжээний кабель, ус, тос, түлш, хийн хоолой, бусад сүлжээ, холболтын байгууламжийг газар дор байгуулна. Түүнчлэн үйлдвэрлэлийн тусгай зориулалтаар барьсан газар доорх барилга байгууламж эсхүл ямар нэгэн бүтцэд далд суурилуулсан цахилгаан болон цахилгааны бус эрчим хүчний далд байгууламжийг газар дор байгуулна.

Хоёр. Газар хөндөх бэлтгэл ажил

- 2.1. Газар хөндөх ажлыг удирдан гүйцэтгэх ажилтан тухайн ажлын төлөвлөгөөг мэргэжилтний хамт боловсруулж, зураг төслийн хамт уул хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 2.2. Аливаа газар хөндөх ажлыг удирдаж байгаа ажилтан нь ажлаа эхлэхийн өмнө түүнд тохирсон арга технологи, техник, тоног төхөөрөмж сонгож авсан эсэхийг урьдчилан шалгаж, бэлтгэл ажлаа хангана. Мөн эдгээр техник тоног төхөөрөмжийг ажиллуулах хүмүүс шаардлагатай сургалт зааварчилгаанд хамрагдсан, мэргэжлийн үнэмлэхтэй эсэхийг шалгаж, баталгаажуулсан байна.
- 2.3. Тухайн орчинд байгаа эрчим хүчний эх үүсвэрийг олж тэмдэглэн журмын дагуу бүрэн тусгаарлаж салгасан байх шаардлагатай бөгөөд салсан эсэхийг мэргэжлийн ажилтнаар шалгуулсны дараа уг ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоно.
- 2.4. Энэ журмын 2.3-т заасанчлан бүрэн тусгаарлах боломжгүй тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Ажлын аюулын шинжилгээ хийсний дараа шаардлагатай эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч журмын дагуу ажиллана.

Гурав. Газар хөндөх зөвшөөрөл

- 3.1. Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан маягтын дагуу газар хөндөх зөвшөөрлийг хүснэ.
- 3.2. Газар хөндөх тухай хүсэлт болон түүний дагалдах материалд дор дурдсан мэдээллийг оруулсан байна.
 - а. Газар хөндөх зөвшөөрөл хүссэн ажилтны мэдээлэл;
 - б. Газар хөндөх ажлын төлөвлөгөө;
 - в. Байршлын зураг, координат;
 - г. Ухах, өрөмдөх хэмжээ метрээр (өргөн, урт, гүн);
 - д. Өртөх талбай болон хөрсний хэмжээ;
 - е. Тухайн ажлыг хийх ажилтны нэр, нэгж хэлтэс, огноо, хугацаа;

ё. Онцгой байдал үүссэн үед авах арга хэмжээ болон хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмж (хий хэмжих багаж г.м).

- 3.3. Газар шорооны ажил хийх нэгжийн ахлах ажилтан нь энэ журмын нэгдүгээр хавсралтад заагдсан Газар хөндөх зөвшөөрлийн маягтыг бөглөн холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлнэ.
- 3.4. Шугам хоолой, байгууламж, сүлжээг үзэж шалгах доор дурдсан мэргэжилтэн нь газар хөндөх төлөвлөгөөтэй танилцаж санал, дүгнэлтээ өгөх бөгөөд шаардлагатай бол тухайн ажлыг хийхийн өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж гүйцэтгүүлнэ.
- а. Цахилгааны кабель – Цахилгааны инженер, Маркшейдер
 - б. Утасны болон сүлжээний кабель – Сүлжээний инженер, Маркшейдер
 - в. Усны шугам хоолой – Сантехникийн инженер, Маркшейдер
 - г. Бохирын шугам хоолой – Сантехникийн инженер, Маркшейдер
 - д. Түлшний болон, хийн шугам хоолой – Маркшейдер тус тус зөвшөөрөл өгнө.
- 3.5. Газар хөндөх ажлыг эхлүүлэхийн өмнө дараах ажилтан гарын үсэг зурж баталгаажуулсны дараа зөвшөөрөл өгөгдсөнд тооцно.
- а. Газар хөндөх зөвшөөрлийг хүссэн ажилтан;
 - б. Маркшейдер инженер;
 - в. Холбогдох инженер /цахилгааны, сангийн, сүлжээний гэх мэт/;
 - г. Байгаль орчны мэргэжилтэн;
 - д. Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан;
 - е. Хариуцсан нэгжийн удирдлага зэрэг болно.
- 3.6. Энэ журмын 3.5-д заагдсан ажилтан хариуцсан шугам хоолой, барилга байгууламжийн зураг, схем болон холбогдох дүрэм стандартын шаардлага зэргийг шалгаж, зөвшөөрөл олгох эсэхээ шийдвэрлэж бичгээр эсхүл цахимаар хариу мэдэгдэнэ.
- 3.7. Уурхайн ажилт болон хөрсний овоолгын тэлэлтийн үед газар хөндөх зөвшөөрөл авахдаа цахилгааны инженер болон сантехникийн инженерээр баталгаажуулах шаардлагагүй ба зөвшөөрлийн маягтад маркшейдер инженерээр тэмдэглэгээ хийлгэнэ.
- 3.8. Газар хөндөх зөвшөөрлийн маягтын 2-р нүүрний байгаль орчны мэргэжилтний бөглөх хүснэгтэд байгаа Байгаль орчны нөлөөлөл, тэдгээрийг бууруулах, арилгах арга хэмжээ болон уг газар шорооны ажлыг хийсний дараа нөхөн сэргээлт хийх шаардлага, нөхцөлүүдийг Байгаль орчны мэргэжилтэн болон удирдан зохион байгуулж байгаа ажилтан нь тодорхой зааж оруулах үүрэг хүлээнэ.
- 3.9. Байгаль орчны мэргэжилтэн нь хүсэлтийн материалтай танилцаж, газар хөндөх зөвшөөрлийн дугаарыг олгоно.
- 3.10. Аль нэг талын гарын үсэг, хавсралт мэдээ, Байгаль орчны болон бусад мэргэжилтний санал зөвлөмж тусгагдаагүй тохиолдолд тухайн зөвшөөрлийг хүчингүйд тооцно.
- 3.11. Шимт хөрс хуулах зөвшөөрөл авах үйл ажиллагааг “Шимт хөрстэй ажиллах журам”-аар зохицуулна.
- 3.12. Газар хөндөх зөвшөөрөл нь тухайн ажлыг гүйцэтгүүлэхээр өгсөн огноо, цаг хугацаанд хүчинтэй байх бөгөөд энэ өгөгдсөн хугацаанд уг ажлыг төлөвлөгөөний дагуу заавал гүйцэтгэнэ. Хэрэв хугацаандаа багтаж хийгээгүй тохиолдолд дахин зөвшөөрөл авч ажиллана.
- 3.13. Дараах тохиолдолд газар хөндөх буюу газар шорооны ажлыг хийхийг хориглоно.
- а. Хүсэлтийг хариуцсан нэгжийн удирдлага болон бусад холбогдох мэргэжилтэн, инженер батлаагүй бол;
 - б. Археологи, палеонтологийн дурсгалт олдвор олдсон бол; (үүнийг Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу тусгай журмаар зохицуулна).
 - в. Шаардлагатай багаж тоног төхөөрөмж дутуу, ялангуяа ухалт малталтын ажлын үед ганцаараа уг ажлыг гүйцэтгэх тохиолдолд;

- г. Орчны нөхцөл байдал, цаг агаарын онц ноцтой үзэгдэл үүссэн үед;
д. Багаж, тоног төхөөрөмжид эвдрэл үүсэж, цаашид тухайн ажлыг хийх боломжгүй үед.

**Дөрөв. Өөрчлөлтийг зурагт тэмдэглэх,
нүхийг буцаан булах ажил**

- 4.1. Ажлыг гүйцэтгэж дуусах үед маркшейдер тухайн ажлын үед хийгдсэн аливаа шугам хоолой, байгууламжийн өөрчлөлт, хөдөлгөөнийг хэмжин зурагт тэмдэглэж хадгалах үүрэгтэй бөгөөд тэмдэглэгээ хийгдсэний дараа тухайн газар шорооны ажлыг хариуцан хийлгэж буй удирдах албан тушаалтан буцаан хааж булах ажлыг зохион байгуулж гүйцэтгэнэ.
- 4.2. Хэрэв ухсан нүх, сувгийг шууд булах боломжгүй бол маркшейдер шаардлагатай тэмдэглэгээг зохих журмын дагуу хийнэ.
- 4.3. Газар шорооны ажил хийсний дараа уг зөвшөөрөлд заасан шаардлагын дагуу нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн Байгаль орчны ажилтанд хүлээлгэн өгөх үүргийг тухайн газар шорооны ажлыг хариуцан хийлгэж буй удирдах ажилтан хүлээнэ.

Тав. Хяналт, шалгалт

- 5.1. Газар хөндөх зөвшөөрөлд шаардлагатай бэлтгэл арга хэмжээнүүд авагдаж, холбогдох албан тушаалтнууд зөвшөөрөн гарын үсэг зурж баталгаажуулах хүртэл газар хөндөх ажлыг эхлүүлэхийг хориглоно.
- 5.2. Газар хөндөх ажлын явцад шаардлагатай бол компанийн болон гэрээт компанийн мэргэжилтний төлөөлөл байнгын хяналт тавьж оролцоно.
- 5.3. Энэ журмын 5.2-т зааснаар байнгын хяналт тавих шаардлагатай тохиолдолд уг албан тушаалтныг томилон тухайн зөвшөөрөлд нэрийг нь бичиж оруулахаас гадна хэрхэн хяналт тавих талаар товч тэмдэглэл хийлгэнэ.
- 5.4. Тухайн ажлыг удирдан хийлгэж байгаа ахлах ажилтан нь хаалт хамгаалалт, тэмдэг тэмдэглэгээ зэрэг уг ажлын аюулгүй байдлыг бүрэн хангахад шаардлагатай арга хэмжээг ажил эхлэхээс дуусах хүртэл хариуцан хэрэгжүүлнэ.

Зургаа. Далд байгууламжийн ойр газар хөндөх

- 6.1. Аливаа далд байгууламжийн орчимд газар ухах, өрөмдөх бол мэргэжлийн ажилтнаар урьдчилан шалгуулж дор дурдсан нөхцөлийн дагуу шалгаж, эрчим хүчний эх үүсвэрийг салгах, тусгаарлах арга хэмжээ авна. Тухайлбал, ямар нэг хяналтгүй энергийн үйлчлэлд хүн болон тоног төхөөрөмж өртөх магадлалыг бууруулах арга хэмжээг авна.
- а. Барилга байгууламжийн зураг, төлөвлөлт;
б. Цахилгаан хэлхээний зураг, схем;
в. Тоног төхөөрөмжийн үйлдвэрийн гарын авлага, зураг схем зэргийг үзэж шалгана.
- 6.2. Ямар нэгэн далд байгууламжийн ойр ажиллах бүх ажилтан энэхүү журмын хүрээнд үйл ажиллагаагаа зохицуулан ажиллах үүрэгтэй бөгөөд зохих журмын дагуу хамгаалах хэрэгсэл өмссөн шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан байна.

Долоо. Бүртгэл, тайлан

- 7.1. Газар хөндөх зөвшөөрлийн маягтын дугаарыг давхцуулахгүйгээр дугаарлах ба дугаарлах үүргийг салбарын байгаль орчны мэргэжилтэн хариуцна.
- 7.2. Газар хөндөх зөвшөөрлийн батлагдсан эх хувийг хадгалан мэдээ болгон ашиглах ба хуулбарыг тухайн газар хөндөх зөвшөөрөл хүссэн хэлтэс, гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтэнд ирүүлнэ.
- 7.3. Байгаль орчны мэргэжилтэн уурхайн бүсэд ашиглагдаж буй, хөндөгдсөн газрын хэмжээ, байршлын талаарх мэдээллийг сар, улирал, жил бүрийн тайланд тусгана.

- 7.4. Газар хөндөх үеийн шимт хөрс хуулах, хадгалах үйл ажиллагааг “Шимт хөрстэй ажиллах журам”-аар зохицуулна.

Найм. Ухалт, малталтын аюулгүй байдал

- 8.1. Ухалт, малталтын ажил хийх бүх төхөөрөмж нь найдвартай ажиллагаатай радио холбоогоор тоноглогдсон байна.
- 8.2. Аливаа далд байгууламжид 0.6 метр ойртсон тохиолдолд ухах малтах ажлыг цааш гараар хийж гүйцэтгэнэ.
- 8.3. Аливаа далд шугам хоолой, байгууламжийг гэнэтийн байдлаар нураах, гэмтээх тохиолдолд ажлын хэсгийн ахлагч нь холбогдох удирдах ажилтанд нэн даруй мэдэгдэж, ойролцоо байгаа хүмүүсийн эрүүл мэнд аюулгүй байдалд нөлөөлөх эсэхийг нягтлан шалгах үүрэгтэй.
- 8.4. Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын материал, чулуу, зэрэг хэрэглэж буй эд зүйлсийг суваг шуудуу болон малталтын дээд ирмэгээс 1 метрээс багагүй зайд байлгана.
- 8.5. Суваг шуудуу болон малталтын хэсэг рүү эд зүйлсийг оруулахдаа аль нэг ханын дагуу гулсуулах маягаар аюулгүй байдлаар хийж гүйцэтгэнэ.
- 8.6. Хэрэв 1.2 метрээс илүү гүнтэй суваг шуудуунд орж ажиллах бол дараах аюулгүй ажиллагааны арга хэмжээг авсан байна.
- а. Хамгаалалтын бэхэлгээ хийх;
- б. 1.2 метрээс илүү урттай материалыг суваг шуудууны ханыг дагуулан 45°-ын налуутайгаар байрлуулах зэрэг болно.

Ес. Эргэж булах ажиллагаа

- 9.1. Эргэж булах ажлын үед гэмтэл хохирлыг урьдчилан сэргийлэх зорилгоор дэд бүтэц, эд зүйлсийг зохих хэмжээгээр бэхэлнэ.
- 9.2. 1.2 метрээс илүү гүн суваг шуудууны ажил гүйцэтгэж байх үед суваг шуудууны гадна аюул осолтой байдлыг мэдэгдэх, онцгой нөхцөл байдалд тусламж үзүүлэх зорилгоор нэг ажилтныг ахлагч томилон ажиллуулна. Энэ ажилтан онцгой нөхцөл байдлын горимыг мэддэг байхаас гадна тусламж дуудах бүрэн боломжтой холбооны хэрэгслээр хангагдсан байна.
- 9.3. Нүх, суваг шуудууны хажууд байрлах овоолгын хананы налуу босоо өнцгийн 33°-аас 1.5 дахин илүү өнцгөөс огцом бол хамгаалалтын бэхэлгээ хийх шаардлагатай.
- 9.4. Өндөр хүчдэлийн шугам, кабелийн трассын ойролцоо суваг шуудуу ухах, малталт хийх үед шугамын хүчин чадлаас хамаарч тулгуураас хамгаалалтын зурвасын төгсгөл хүртэлх зай хэмжээнээс гадна зайд хийж гүйцэтгэнэ.
- 9.5. Суваг шуудуу болон малталтын хэсгийн хамгаалалтын бэхэлгээг газрын гадаргаас 0.3 метрээс багагүй өндөртэйгөөр барих ба мэргэжлийн инженерээр хянуулж батлуулна.
- 9.6. Суваг шуудууны бүхий л орох, гарах хэсэгт аюулгүй байдлыг хангасан байна.
- 9.7. Ажилтан нь суваг шуудуу болон малталтын ажил гүйцэтгэж буй тоног төхөөрөмжөөс 3 метрээс багагүй зайд байрлана.
- 9.8. Суваг шуудуу болон малталтын ажил гүйцэтгэж байгаа ажилтан нь тухайн ажилд мэргэшсэн эсэхийг хэсгийн ахлагч болон мастер нягтлан шалгана.
- 9.9. Туг, тууз, хаалт зэргийг тээврийн хэрэгсэл болон явган зорчигч явах хэсгүүдэд байрлуулсан байх шаардлагатай. Мөн онгорхой ирмэгүүдэд хаалт, тууз болон хамгаалалтын далан хийнэ.

Арав. Хариуцлага

- 10.1. Энэ журмыг заалтыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

Газар хөндөх зөвшөөрлийн маягт

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК

ERDENES
ALT RESOURCE
LLC9020030288
5288754 А СБТ11352
УЛААНБААТАР ХОТ

❖ Хүсэлт гаргагч бөглөнө:

Хүсэлт гаргасан огноо:		ГХЗ №:	
Хүсэлт гаргасан хэлтэс/Гэрээт компани:			
Хүсэлт гаргасан ажилтны нэр:		Утас:	
Хэлтэс нэгж:		Албан тушаал:	
Газар шорооны ажлын байршил:		☒ Уурхайн оффис ☐ Засварын шоп	
☐ Бусад (бичнэ үү)			
Байрлалын талаарх нэмэлт тайлбар:			
Газар хөндөх шалтгаан: ☐ Барилгын ажил ☐ Хөрс хуулах ☐ Шинэ зам тавих			
☐ Өнгөн хөрс хуулах ☐ Мод, ургамал тариалах ☐ Хог/бохирын нүх ухах			
☐ Хаалт, хашаа барих ☐ Бусад (бичнэ үү)			
Ажлын танилцуулга өгсөн эсэх?		☐ Ажлын төлөвлөгөө ☐ Байршлын зураг	
☐ Бүдүүвч зураглал		☐ Гэрэл зураг ☐ Бусад (бичнэ үү)	
Газар доорх болон дээрх байгууламжийг зурагт тэмдэглэж хавсаргасан эсэх?			☐ Тийм ☐ Үгүй
Ажлын тодорхойлолт (Уг ажлыг гүйцэтгэх арга, төлөвлөгөө, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг товч тодорхой тусгана).			
Ажил дуусахад нөхөн сэргээлтийг хэрхэн хийх тухай мэдээлэл:			
Нөхөн сэргээлт хийх товч төлөвлөгөө:			
Өртөх талбайн хэмжээ (м ²)			
Хөрс хуулалтын хэмжээ (м ³)			
Үүнээс:	☐ Шимт хөрс (м ³)	☐ Хаягдал хөрс (м ³)	
Ажил гүйцэтгэх хугацаа:		Эхлэх цаг:	Огноо:
		Дуусах цаг:	Огноо:
Хяналт тавих нөхцөл:			
Газар дээр нь хяналт тавих ажилтнууд:			
“ЭАР” ХХК-ийн төлөөлөл:		Гэрээтийн төлөөлөл:	
Овог нэр:		Овог нэр:	
Овог нэр:		Овог нэр:	
Баталгаажуулалт:			
Тухайн ажлыг газар дээр нь хариуцан зохион байгуулах ажилтан (ЭАР ХХК-ийн эсхүл Гэрээтийн ээлжийн мастер, ахлах ажилтан, талбайн инженер г.м):			
Овог нэр:		Албан тушаал:	
Энэхүү ажлыг гүйцэтгэхэд шууд болон шууд бусаар оролцох бүх ажилтан өөрсдийн ажил үүргээ, дээр тодорхойлсон ёсоор аюул эрсдэлгүй аргаар, цаг хугацаанд нь			

чанартай хийж гүйцэтгэхэд шаардлагатай бүх нөхцөлөөр хангаж ажиллах үүрэг хариуцлага хүлээсэн гэдгээ миний бие ойлгож хүлээн зөвшөөрч байна.

Гарын үсэг:

Огноо:

❖ **Мэргэжилтнүүд бөглөнө:**

Хариуцлагатай ажилтны зөвшөөрөл (Гарын үсэг зурж зөвшөөрөл өгсөнөө баталгаажуулна):

Байгаль орчны мэргэжилтэн:		Огноо:	
Цахилгааны инженер:		Огноо:	
Сүлжээний инженер:		Огноо:	
Маркшейдер:		Огноо:	
Сан болон усны техникч:		Огноо:	
ХАБ-ын инженер:		Огноо:	
Хариуцсан хэлтсийн удирдлага:		Огноо:	

Ажил эхлэхээс 24 цагийн өмнө бүх гарын үсэг зурагдсан байна.

❖ **ХАБЭАБО хэсэг бөглөнө:**

Байгаль орчны асуудал:		
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, хүрээнд байгаа эсэх?	☐ Тийм	☐ Үгүй
Төрийн байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай эсэх?	☐ Тийм	☐ Үгүй
Унд, ахуйн болон бусад усны эх үүсвэрт ойр байгаа эсэх?	☐ Тийм	☐ Үгүй
Ховордсон амьтан ургамал өртөх эсэх?	☐ Тийм	☐ Үгүй
Бохирдол хязгаарлах арга хэмжээ авагдах шаардлагатай эсэх?	☐ Тийм	☐ Үгүй
Тоосны эх үүсвэрийг багасгах шаардлагатай эсэх?	☐ Тийм	☐ Үгүй
Ажлын явцад байгаль орчны нөлөөллийг хянах талаар тэмдэглэл:		
Байгаль орчны нөхцөл байдлын талаар тэмдэглэл:		
Ажил дууссаны дараа нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн тухай тэмдэглэл:		

Журмын хяналтын хуудас

Баримт бичгийн нэр	Газар хөндөх журам
Баримт бичгийн код	ЭАР-БО-Ж06-И/18
Тодорхойлолт	"Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн уурхайн бүсэд хийгдэх аливаа газар хөндөх ажлыг төлөвлөж гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулах
Анхны зохиогч	Ш.Намсрайжав, Г.Анх-Амгалан /Байгаль орчны мэргэжилтэн/
Үүсгэсэн огноо	
Баталсан албан тушаалтан*	
Баталсан огноо*	

Нэмэлт өөрчлөлт

Хувилбар	Хянан засварласан огноо	Хянасан	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1				
2				

* Журам, горим, зааврын хамгийн эхний хувилбарыг баталж буй тохиолдолд бөглөнө.



ХОГ ХАЯГДЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн үйл ажиллагаанаас гарах энгийн болон аюултай хог хаягдал, тэдгээрийг эх үүсвэр дээр нь багасгах, бууруулах, байгаль орчинд ээлтэй байдлаар зайлуулах, хадгалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам нь уурхайн бүх хэсэг, нэгж, туслан гүйцэтгэгч гэрээт компани, тэдгээрийн ажилтнууд, түр зочдод нэгэн адил хамаарна.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1. Уг журмыг хэрэгжүүлэхэд дараах хэлтэс, нэгжүүд хамаарна.
- 2.2. Байгаль орчны мэргэжилтэн журмын хэрэгжилтийг хангуулах буюу үл нийцлийг арилгуулахад чиглэсэн зөвлөмж хүргүүлэх, нэгдсэн бүртгэлийн сан хөтөлж мэдээлэлд статистик шинжилгээ хийх, эргэх холбоог хангах, тэмдэглэл хөтлөхөд үндэслэн тогтолцоонд байнгын сайжруулалт хийх;
- 2.3. Нийт хэлтэс нэгжийн удирдлагууд журмын хэрэгжилтийг хангуулах;
- 2.4. Нийт хэлтэс нэгж, гэрээт компаниуд аюултай хог хаягдлын удирдлагыг компанийн менежментийн төлөвлөгөөний дагуу хариуцаж ажиллах;
- 2.5. Гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтэн, эрүүл ахуйч, катерингийн үйлчилгээний ажилтнууд журмын хэрэгжилтийг хангах;

Гурав. Хог хаягдлын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

- 3.1. “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн үйл ажиллагааныхаа явцад гарах хог хаягдлыг хамгийн бага хэмжээнд байлгах, хог хаягдал үүсгэхээс зайлсхийх, дахин ашиглах, хог хаягдлыг хадгалахдаа байгаль орчинд ээлтэй байх зарчмыг баримтлах;
- 3.2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бүртгэл хөтлөхөд оролцох хэлтэс, нэгж тэдгээрийн ажилтнуудын уялдаа холбоог харуулах;
- 3.3. Хог хаягдлын эх үүсвэр бүрээс дээж авч бохирдлын үзүүлэлтийг тогтмол хянах, үйл ажиллагаанаас гарсан бүхий л төрлийн хог хаягдлыг дахин боловсруулахад анхаарах, байгаль орчинд халгүйгээр хадгалах, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагад шилжүүлэх;
- 3.4. Бараа материал нь хог хаягдлыг хамгийн бага үүсгэх, дахин ашиглаж эсвэл үйлдвэрлэгч руу түүхий эд болгон буцааж болохуйц савлагаатай, эко шийдэлтэй буюу буцаан боловсруулах амьдралын мөчлөгт бүтээгдэхүүн нийлүүлэгчийг урамшуулах тогтолцоог худалдан авалтын бодлогод тусгах;

Дөрөв. Хог хаягдлын ангилал, төрөл

- 4.1. Уурхайн оффис, ажилчдын хотхон, засварын цех, лаборатори, яаралтай тусламжийн нэгжээс гарах бүхий л төрлийн хог хаягдлыг хамруулах ба дараах байдлаар ангилна. (Хог хаягдлын нэр төрөл нь дараах байдлаар хязгаарлагдахгүй.)
 - Энгийн хог хаягдал (Хавсралт 1)
 - Аюултай хог хаягдал (Хавсралт 2)

Тав. Хог хаягдлыг ангилан ялгах, зайлуулах

- 5.1. Энгийн хог хаягдал гэдэгт дараах зүйлс хамаарна.

- 5.1.1. Ус, ундааны хуванцар савыг **НОГООН** өнгийн саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт хүргэнэ.
- 5.1.2. Хоол үйлдвэрлэлээс гарсан хүнсний хаягдал, хоолны үлдэгдлийг катерингийн компанийн үйлчилгээний ажилчид ангилан ялгаж **БОР** өнгийн саванд цуглуулж, органик бордоо болгох дэвшилтэт технологийг туршина.
- 5.1.3. Картонон цаасны хаягдлыг цуглуулж цаас дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.
- 5.1.4. Бусад төрлийн хог хаягдал буюу салфетка, ариун цэврийн цаас, гялгар уут, нэг удаагийн хоолны пакет, таваг, аяга, шаазан эдлэл, даавуу гэх мэтийг энгийн хог хаягдал хадгалах буюу **ХАР** өнгийн саванд цуглуулж нэгдсэн хогийн цэгт хүргэнэ.
- 5.1.5. Төмөр, модны хаягдлыг уурхай дахь хог хаягдлын цэгт цуглуулан дотоодын хэрэгцээнд ашиглах эсвэл хоёрдогч түүхий эд авах цэгт тушаана.
- 5.1.6. Бичгийн цаасны хаягдлыг **ЦЭНХЭР** өнгийн саванд цуглуулж цаас бутлагч машинаар жижиглэсэн байдлаар устгана.
- 5.2. Аюултай хог хаягдал дараах зүйлс хамаарна.
 - 5.2.1. Ашиглаж дууссан бүх төрлийн принтерийн хорыг байгаль орчны мэргэжилтэнд авч ирж өгөх ба эдгээрийг агуулахад цуглуулан ханган нийлүүлэгч байгууллагад буцаан өгөх байдлаар хаягдлыг бууруулна.
 - 5.2.2. Агаар шүүгч, тосны шүүр, галын хорны баллон, хийн баллон, дугуй, тос маслоны төмөр торх, товудны үлдэгдэл, будаг, цавууны сав, засварын цехээс гарсан сав баглаа боодлын (зэв арилгагч, шүршигч, будаг шингэлэгч гэх мэт) хаягдлыг уурхайн талбай дах хог хаягдал түр хадгалах байгууламжид хураах ба уурхайн талбайгаас гаргах, хээр ил задгай хаях, булахыг хориглоно. Шатамхай шинж чанартай аюултай хаягдлуудыг зөвхөн зориулалтын зууханд шатааж, эргүүлэн ашиглана (жишээ нь: тосны шүүрийг замын тэмдэг, тэмдэглэгээнд ашиглах).
 - 5.2.3. Цэвэрлэгээний бодисын хуванцар сав, тос маслоны хуванцар сав, баглаа боодол, торх, тос, маслоор бохирдсон арчих материал, ажилласан масло буюу хаягдал тос масло, галын хорны нунтаг, товудны үлдэгдэл зэргийг **УЛААН** өнгийн саванд цуглуулж тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагад шилжүүлнэ.
 - 5.2.4. Бүх хэлтэс, нэгжүүдэд батерей цуглуулах хайрцаг байршуулах ба хаягдал батерейг 14 хоног тутамд байгаль орчны мэргэжилтнүүд цуглуулж агуулахад хадгална. Хуримтлагдсан хаягдал батерейг Монголын хог хаягдал дахин боловсруулах үндэсний холбоонд тушаана.
 - 5.2.5. Яаралтай тусламжийн нэгжээс гарсан эм, эмнэлгийн халдварт багаж хэрэгсэл, нэг удаагийн зүү тариур зэргийг ЯТН-ийн өрөөнд цуглуулан, сум дундын эмнэлэгт хүргэж зориулалтын дагуу устгах ба гарах хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэхдээ 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Эрүүл мэндийн сайдын А/505 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”-ыг мөрдлөг болгоно.

Зургаа. Хог хаягдлын цэгт тавигдах шаардлага, мониторинг

- 6.1. Хог хаягдал цуглуулах, хадгалах цэг нь тодорхой тэмдэглэгээтэй, уурхайн схем зурагт заавал тэмдэглэгдсэн байх бөгөөд орон нутгийн холбогдох шатны байгууллагаас зөвшөөрөл авсан.
- 6.2. Энгийн болон аюултай хог хаягдлыг тусад нь хадгалах ба хогийн савнуудыг өнгөөр ялгаж тэмдэгжүүлсэн байх ба зөвхөн тухайн тэмдэгтэй хогийг хадгална.

- 6.3. Нойтон хог хаягдал урсах, тос масло хөрсөнд шингэж бохирдохоос сэргийлж газрын гадаргууг цементэлж тусгаарласан байх шаардлагатай.
- 6.4. Хог хаягдал цуглуулах сав нь Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд тусгагдсан заалтуудыг хангасан байх, орчин үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн савыг байршуулсан байна.
- 6.5. Хаягдал тос цуглуулах байгууламж нь уурхайн засвар үйлчилгээнээс гарах тосны хаягдлыг 2 сар цуглуулах хүчин чадалтай байх ба нийт багтаамжийн 75 хувь нь дүүрсэн тохиолдолд суллах арга хэмжээг авна.
- 6.6. Ууршилтгай, шатамхай, тэсэрч дэлбэрэх хаягдлыг битүүмжлэл бүхий төмөр саванд хадгална.
- 6.7. Хаягдал тос цуглуулах ёмкости дүүрэлт, цооролт зэргийг тогтмол хугацаанд шалгаж байх бөгөөд хаягдал тос цуглуулах талбайн нэвчилтийг хянах үүднээс жилд 1 удаа бетонон шалыг өрөмдөж хөрсний дээж авч хүнд металлын агууламжийг шинжлүүлнэ.
- 6.8. Ажилчдын хотхоны хүчин чадалд нийцсэн бага оврын ус цэвэрлэх байгууламжтай байх бөгөөд энэ нь MNS 4288:1995 стандартад нийцсэн технологитой, батлагдсан зураг төслийн дагуу баригдсан, бохир усыг MNS 4943:2015 хаягдал усны стандартад нийцтэл цэвэрлэдэг байх, эсвэл бохир ус цэвэрлэх орчин үеийн дэвшилтэт технологи бүхий септик системийг суурилуулж, гарч буй хаягдал усны чанарт байнгын шинжилгээ хийж байх шаардлагатай. Бохир усыг улиралд 1 удаа шинжлүүлэх ба MNS 4943:2015 стандартад заасан үзүүлэлтийг (БХХ, ХХХ, Умбуур бодис гэх мэт) шинжлүүлнэ. Стандартад нийцээгүй тохиолдолд орон нутгийн бохир ус хүлээн авах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж нийлүүлэх, засвар үйлчилгээ хийж цэвэрлэгээний процессыг сайжруулах гэх мэт арга хэмжээ авна.
- 6.9. Агаар бохирдуулагч хийн хаягдлын шинжилгээг жилд 2 удаа хийх бөгөөд уурын зуухны салхин доод хэсгээс сорьц авна. Хийн хаягдлын шинжилгээгээр агаар бохирдуулагч бодис (SO_2 , NO_2 , CO) MNS 4585:2016 стандартаас хэтэрсэн байвал шүүлтүүрийг солих арга хэмжээ авна.
- 6.10. Энгийн хог хаягдлын цэгийн орчмоос улиралд 1 удаа хөрсний дээж авч эрүүл ахуйн үзүүлэлтийг, аюултай хог хаягдлын цэгийн орчмоос жилд 2 удаа хөрсний дээж авч хүнд металлын агууламжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлнэ.
- 6.11. Хог хаягдал цуглуулах, хадгалах цэгт тогтмол хугацаанд ажлын байрны үзлэг хийх ба гарсан зөрчлүүдийг баримтжуулж, зөрчлийг тухай бүр арилгаж, бүртгэлийн системд мэдээллийг хадгална.

Долоо. Бүртгэл, мэдээ, тайлан

- 7.1. Үйлдвэрийн бүх салбар, ажилчдын хотхоноос үүсэж буй хаягдлын хэмжээ, төрөл, эрсдэл, дахин боловсруулалт, хадгалалт, устгалын хэлбэр, хог хаягдлын байгууламжуудын ашиглалт, засвар үйлчилгээ, үнэлгээ, хог хаягдлын эх үүсвэр орчмоос авсан агаар, ус, хөрсний дээжид хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээний дүнг зааврын дагуу сар бүр мэдээлнэ.
- 7.2. Дээрх болон бусад хог хаягдлын асуудалтай холбоотой бүх мэдээллийг "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэнд нэгтгэж мэдээллийн сан хөтөлнө.

Найм. Тээвэрлэлт

- 8.1. Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

Ес. Сургалт

- 9.1. Хог хаягдлын журамтай холбоотой агуулгыг багтаасан танилцуулгыг шинэ ажилтны сургалтаас авах ба ажлын байрнаас шалтгаалсан нэмэлт сургалтуудыг тухай бүр зохион байгуулна.

- 9.1.1. Танилцуулах сургалт: Уурхайн талбайд ажиллах үндсэн, гэрээт компанийн нийт ажиллагсдад ордог шинэ ажилтны сургалтын агуулгад уг журамтай холбоотой танилцуулгыг бэлтгэн оруулж, хог хаягдлын зохистой удирдлага, хог хаягдлыг ангилан ялгалтын талаар нэгдсэн ойлголттой болгоно.
- 9.1.2. Ажлын байран дахь сургалт: Хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах, бүртгэл хөтөлж буй голлох ажилчдад зориулан ямар төрлийн хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах, хадгалах, тээвэрлэх мөн дээрх ажлуудыг гүйцэтгэх үед аюулгүй ажиллагаагаа хэрхэн хангах талаар уг сургалтыг явуулна.
- Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.
 - Асгаралтын иж бүрдэл болон гал унтраагчийг хог хаягдлын цэгт заавал байрлуулах ба, уг цэгийн үйл ажиллагааг хариуцсан ажилтнууд эдгээрийг ашиглах сургалтад хамруулсан байна.

Арав. Хариуцлага

- 10.1. Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.



Энгийн хог хаягдлын жагсаалт


Шил, ундаа, усны бүх төрлийн хөнгөн цагаан лааз, хуванцар сав, зөөлөн, хатуу гялгар уут, хоол, хүнсний хаягдал, салфетка, ариун цэврийн цаас, нэг удаагийн хоолны пакет, таваг, аяга, даавуу, барилгын хог хаягдал, картон, цаас, энгийн зуухны үнс.



Аюултай хог хаягдлын жагсаалт

Хатуу	Хий	Шингэн хаягдал
Аккумулятор	Уурын зуухнаас гарах агаар бохирдуулагч хорт хий	Бохир ус
Батерей	Угаарын хий	Ашигласан тос,
Удаагийн бээлий	Нүүрстөрөгчийн дан исэл	Антифриз
Хөвөн бинт	Органик хлорт нэгдлүүд	Хөргөгч бодис
Принтерийн хор		Уусмал
Төрөл бүрийн гуурс		Тосолгооны материал
Шарик		
Сальфетик		
Эм тарианы шил		
Дуслын систем		
Цахилгаан болон цахим тоног төхөөрөмж		
Халууны шил бусад мөнгөн ус агуулсан хаягдал		
Бохирлогдсон зүү, тариур		
Будаг		
Дугуй		
Өдрийн гэрэл		
Хэрэгслийн хаягдал		

Хог хаягдал ангилан ялгах сав



ДАХИН БОЛОВСРУУЛАХ БОЛОМЖТОЙ “ДАХИВАР ХАЯГДАЛ”



ЦААСНЫ ХАЯГДАЛ



ХҮНСНИЙ ХАЯГДАЛ



АЮУЛТАЙ ХАЯГДАЛ



ДАХИН БОЛОВСРУУЛАХ БОЛОМЖГҮЙ БУСАД ХАЯГДАЛ

АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ХАЯГДАЛ

Бүх төрлийн салфетка, оо цаас, шүдний чигчлүүр, нэг удаагийн хоолны пакет, нэг удаагийн аяга таваг, памперс, ариун цэврийн хэрэглэл, тетрапак сав,



1

2

ШАРЖИГНАДАГ ГЯЛГАР УУТ

Талх, нарын боов, чихэрийн уут, сав баглаа боодлын шаржигнасан гялгар



3

4

БУХ ТӨРЛИЙН ДААВУУНЫ ХАЯГДАЛ

Хувцасны хаягдал, төрөл бүрийн утас, хувцас хэрэглэлийн товч, цахилгаан, ахуйн хэрэглээний даавуу



БИЧИГ ХЭРЭГЛЭЛИЙН ХАЯГДАЛ

Үдээс, CD, бал, харандаа, дэвтэрийн хавтас, номын хавтас, сэтгүүл, фото цаас, урилга



ШИЛ, САВ, ШААЗАН, МОДОН ЭДЛЭЛИЙН ХАЯГДАЛ

Хагарсан аяга таваг, хагарсан шил, палантай сав, модон хайрцаг сав



5

6

ЭМИЙН САНГИЙН ХАЯГДАЛ

Модон резинэн тоглоом, эмийн сав баглаа боодол



Анхаарах зүйл:

- Шингэн хаягдал холихгүй байх
- Овор хэмжээ ихтэй хаягдлын хэмжээг нь багасгах
- Дахин боловсруулах боломжтой дахивар хаягдал холихгүй байх

Аюултай хог хаягдал :

Бүх төрлийн батерей, принтерийн хор, эмнэлгийн хаягдал, фирон амиак агуулсан хаягдал, халууны шил, өдрийн гэрэл, даралтны аппарат зэрэг олон төрлийн хаягдал орно.



**ALT RESOURCE
LLC**

Компанийн нэр		Байгууллагын нэр:																																	
Хэмжих нэгж		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	Нийт		
ХАЯГДЛЫН ТӨРӨЛ	Цаас	кг																																	
	Хуванцар	кг																																	
	Шил	кг																																	
	Хоолны үлдэгдэл	кг																																	
	Хүнсний хаягдал	кг																																	
	Лааз	кг																																	
	Картон цаас	кг																																	
	Үнс	тн																																	
	Барилгын хаягдал	тн																																	
	Бусад	тн																																	
		ҮННЭЭС																																	
Хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлсэн																																			
Дахин боловсруулсан																																			
Дахин ашигласан																																			
Хадгалж байгаа																																			
Тайлбар		ЭНГИЙН - Катерингийн компанийн үйлчилгээний ажилтан, менежер бөглөнө.																																	
Бүртгэл хөтөлсөн ажилтны албан тушаал																	Овог нэр																		
Хянасан ажилтны албан тушаал																	Овог нэр																		



Хог хаягдлын журмын тавдугаар хавсралт

Аюултай болон бусад төрлийн хог хаягдлын бүртгэлийн хуудас

Компанийн нэр			Байгууллагын нэр: 8020030288 8283764-4-00011032 УЛААНБААТАР АОТ																																
ХАЯГДЛЫН ТӨРӨЛ			Хэмжих нэгж	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	Нийт
АЮУЛТАЙ	Агаар шүүгч	ш																																	
	Тосны шүүр	ш																																	
	Хаягдал сав, торх (поошиг)	ш																																	
	Аккумулятор	ш																																	
	Хаягдал дугуй	ш																																	
	Арчих материал /даавуу/	кг																																	
	Галын хорны баллон	ш																																	
	Хийн баллон	ш																																	
	Батерей	кг																																	
	Хаягдал тос, масло	л																																	
Бусад	Эмнэлтийн хаягдал	кг																																	
	Төмөр	тн																																	
	Мод	тн																																	
	Авто машины эд анги	тн																																	
			ҮНЭЭС																																
Шатаасан																																			
Хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлсэн																																			
Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн																																			
Хадгалж байгаа																																			
Тайлбар			АЮУЛТАЙ - ТАЗМХ, БОУБХ, ЯПН, БУСАД - ЗУХ бөглөнө.																																
Бүртгэл хөтөлсөн ажилтны албан тушаал			Овог нэр												Гарын үсэг																				
Хянасан ажилтны албан тушаал			Овог нэр												Гарын үсэг																				



Хог хаягдал тээвэрлэлтийн бүртгэл

Хог хаягдал тээвэрлэсэн ажилтны овог нэр:			
Албан тушаал:		Огноо:	
Байгууллага:			
Ачсан хог хаягдлын төрөл:	Ахуйн хаягдал ☐		Хоолны хаягдал ☐
Цаасан хайрцаг ☐	Хуванцар сав ☐		Бусад ☐
Аюултай хог хаягдал ☐			
Аюултай хог хаягдлыг дэлгэрэнгүй бичнэ үү.			
Бусад төрлийн хог хаягдлыг дэлгэрэнгүй бичнэ үү.			
Хог хаягдал тээвэрлэсэн газар	Тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ (тн)	Хог хаягдал ачиж буулгасан хугацаа	
		Ачсан	Буулгасан
Хог хаягдал тээвэрлэх журмын дагуу хучилт хэрэглэсэн эсэх:		Тийм ☐	Үгүй ☐
(Хэрэв үгүй бол тайлбарыг бичнэ үү)			
Хог хаягдлыг буулгасан газрын байршил			
Хог хаягдал тээвэрлэсэн ажилтны нэр, гарын үсэг:		/	/
Хог хаягдал ачсан ажилтны нэр, гарын үсэг:		/	/
Хүлээн авсан ажилтны нэр, гарын үсэг:		/	/
Хяналт тавьсан ажилтны нэр, гарын үсэг:		/	/



Яаралтай тусламжийн нэгжээс гарсан хог хаягдлын бүртгэл

❖ **ЯТН-ийн ажилтан бөглөнө.**

Бүртгэл хөтөлсөн ажилтны овог нэр:			
Албан тушаал:		Огноо:	
Байршил:	Уурхайн ЯТН ☐	Хотхоны ЯТН ☐	Бусад ☐
Эмнэлэгийн хог хаягдлын төрөл		Хэмжих нэгж	Хэмжээ
Халдвартай хог хаягдал			
Аюултай хог хаягдал			
Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж байгаа эсэх:		Тийм ☐	Үгүй ☐
Бүртгэл хөтөлсөн ажилтны гарын үсэг:			
Бүртгэлийг баталгаажуулсан ажилтны гарын үсэг:			

❖ **ЯТН-ын аюултай хог хаягдал устгасан ажилтан бөглөнө.**

Ажилтны овог нэр:		Огноо:	
Албан тушаал:		Ээлж:	
Байршил:			
ЯТН-ын хог хаягдлыг хүлээлгэн өгсөн ажилтны овог нэр:			
Албан тушаал:			
ЯТН-ын хог хаягдлыг хүлээж авсан ажилтны овог нэр:			
Албан тушаал:			

❖ **Хяналт хийсэн**

Ажилтны овог нэр:		Огноо:	
Албан тушаал:		Ээлж:	



Гэрээгээр хаягдал тос нийлүүлсэн бүртгэл

Огноо:		Бүртгэлийн дугаар:	
Гэрээгээр хаягдал тос авсан байгууллагын нэр:			
Утасны дугаар:		Тос авсан ажилтны нэр:	
Хаягдал тос нийлүүлэх ажилд байлцсан ажилчид:			
"Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн ажилтан:			
"Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн ажилтан:			
Гэрээт байгууллагын төлөөлөл:			
Гэрээт байгууллагын төлөөлөл:			
Олгосон тосны хэмжээ:		тн	литр
Хаягдал тос нийлүүлэх явцад асгаралт гарсан эсэх:		Тийм ☐	Үгүй ☐
Асгаралтын хэмжээ:		тн	литр
Асгаралтын үед авсан арга хэмжээ:			
Асгаралт гарсан байдал		Асгаралтыг хязгаарласан байдал	

Баталгаажуулалт:		
Зөвшөөрсөн:	УБҮ-ийн ахлах:	Гарын үсэг:
Хүлээлгэн өгсөн:	Байгаль орчны мэргэжилтэн:	Гарын үсэг:
Хүлээж авсан:	Гэрээт компанийн ажилтан:	Гарын үсэг:

Журмын хяналтын хуудас

Баримт бичгийн нэр	Хог хаягдлын журам
Баримт бичгийн код	ЭАР-БО-Ж07-И/18
Тодорхойлолт	Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн үйл ажиллагаанаас гарах энгийн болон аюултай хог хаягдал, тэдгээрийг эх үүсвэр дээр нь багасгах, бууруулах, байгаль орчинд ээлтэй байдлаар зайлуулах, хадгалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.
Анхны зохиогч	Ш.Намсрайжав, Г.Анх-Амгалан /Байгаль орчны мэргэжилтэн/
Үүсгэсэн огноо	
Баталсан албан тушаалтан*	
Баталсан огноо*	

Нэмэлт өөрчлөлт

Хувилбар	Хянан засварласан огноо	Хянасан	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1				
2				
3				

* Журам, горим, зааврын хамгийн эхний хувилбарыг баталж буй тохиолдолд бөглөнө.



ӨНГӨН ХӨРСТЭЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн олборлолт, бүтээн байгуулалтад өртөж байгаа талбайгаас шимэрхэг чулуулаг болон шимт хөрсийг нөхөн сэргээлтийн зориулалтаар ашиглахад зориулж хуулах, хадгалах технологийг тодорхойлоход оршино.
- 1.2. Өнгөн хөрсийг эргүүлэн ашиглах ажиллагаа нь нөхөн сэргээлтийн бусад бичиг баримтаар зохицуулагдана.
- 1.3. Энэ журам нь “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн болон уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компани, тэдгээрийн туслан гүйцэтгэгч компанийн ажилтнуудад нэгэн адил хамаарна.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

- 2.1. Шимт хөрс гэж ургамал ургахад шаардагдах үржил шим, агрохими, механик бүрдэл бүхий нөхцөлийг хангасан буюу энгийн сайжруулалт хийх боломжтой хөрсний өнгөн хэсгийг ойлгоно.
- 2.2. Шимэрхэг хөрс гэж ургамлын ургалт, төлжилтөд хязгаарлагдмал хүрээнд таатай нөлөө үзүүлэхүйц физик, хими шинж чанар бүхий уулын чулуулгийг ойлгоно.
- 2.3. Нөхөн сэргээлтэд ашиглагдах боломжтой хөрсний гадаргуугийн дээд хэсгийг буюу шимт хөрс болон шимэрхэг хөрсийг хамтад нь өнгөн хөрс гэж ойлгоно.
- 2.4. Хөрсний урьдчилсан үнэлгээ гэж үйл ажиллагаа явуулах талбайн шимт хөрсийг хуулахаас өмнө хөрсний чанарыг магадлан нөөцийг хэсэгчлэн тогтоох ажиллагаа бөгөөд уг үнэлгээгээр шимт болон шимэрхэг хөрс хуулах зузааныг тогтооно.

Гурав. Өнгөн хөрс хуулах төлөвлөгөө

- 3.1. Тухайн жилд уурхайн ахилтад өртөж хуулагдах талбай, өнгөн хөрс, ялангуяа шимт хөрсний хэмжээ болон овоолго үүсгэн байрлуулах талбайн байршил, хэмжээг ашиглалтын үйл ажиллагааны болон хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгасан байна.
- 3.2. Шимт хөрс хуулахаас өмнө талбайд цэвэр усны эх үүсвэр хөндөгдөх, ховор ургамал өртөх эсэхийг тогтоон шаардлагатай бол нөхөн сэргээлтийн талбайд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.3. Уурхайн ахилтад өртөх талбайд Байгаль орчны мэргэжилтэн хөрсний урьдчилсан үнэлгээг хийнэ. Үнэлгээ нь дараах үндсэн мэдээллүүдийг тусгасан байна.
 - а. Үнэлгээ хийгдсэн талбайд хамрагдаж байгаа хөрсний хэв шинжийг тодорхойлж хөрсний 1:5000 масштабтай зураг боловсруулна
 - б. Талбайд хөрсний тодорхой гүнүүдээс дээж авч шинжлүүлэн хөрсний үржил шим, механик бүрдлийн мэдээлэл, цэвэр усны эх үүсвэр, ховор ургамлын байршлын мэдээллээр зургийг баяжуулна.
 - в. Уулын техникээр олборлох боломжтой, их хэмжээний шимэрхэг хөрс гарах өндөр магадлалтай хэсгүүдийг тодорхойлно
 - г. Хөрсний хэв шинжийн зурагт үндэслэн өнгөн хөрс тус бүрийн хуулах зузааныг тодорхойлсон 1:5000 масштабтай зургийг сектор болгоноор ялгаж гаргана
- 3.4. Хөрсний урьдчилсан үнэлгээг ахилтын 3-аас доошгүй жилээр хийж батлуулан жил бүрийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээ баримт болгон ашиглана.
- 3.5. Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдах өнгөн хөрсний тооцоо нь хөрсний урьдчилсан үнэлгээний мэдээнд үндэслэсэн байхыг эрмэлзэнэ.

Дөрөв. Өнгөн хөрс хуулах явц

- 4.1. Байгаль орчны мэргэжилтэн хөрсний урьдчилсан үнэлгээ, уулын ажлын төлөвлөгөө болон бусад төлөвлөлтийг үндэслэн шинээр газар хөндөх, хөрс хуулах тохиолдол бүрд шимт хөрс хуулах зөвшөөрөл олгоно.
- 4.2. Шимт хөрс хуулах зөвшөөрлийг тус журмын нэгдүгээр хавсралтын маягтын дагуу бөглөн, шимт хөрс хуулах талбайн дэвсгэр зургийн хамт хавсарган Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн байгаль орчны мэргэжилтэн, төлөвлөлтийн инженер, тухайн ажлыг хариуцан хийх ажилтнаар гарын үсэг зуруулан баталгаажуулна.
- 4.3. Шимт хөрс хуулах зөвшөөрөл авахдаа газар хөндөх зөвшөөрлийг хамт авах ба зөвшөөрлийн хуудаснуудыг Байгаль орчны мэргэжилтэн эх хувиар нь хадгална.
- 4.4. Шимт хөрс хуулахаар төлөвлөсөн талбайн хөрс нь барилга, үйлдвэрийн хог хаягдал, чулуу хайрга, хатуу зүйлийн үлдэгдлээр бохирдсон, дайргархаг, хайргархаг, чулуурхаг бүтэцтэй байх эсвэл өмнө нь хүнд даацын машин техник зорчсоноос хөрс элэгдсэн, бохирдсон тохиолдолд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн байгаль орчны мэргэжилтний хамт газар дээр нь очиж үзэн хэсэгчлэн акталж болно.
- 4.5. Шимт хөрс актлахдаа журмын хоёрдугаар хавсралтын маягтыг бөглөн Шимт хөрс актлах зөвшөөрөл авна.
- 4.6. Шимэрхэг хөрсийг хуулахдаа ихэнхдээ мөргөцгөөс шууд ачиж шимэрхэг хөрсний овоолгод тээвэрлэх ба шимэрхэг хөрс хуулах өдрийг урьдчилан тогтоож байгаль орчны мэргэжилтэнг заавал байлцуулна.
- 4.7. Өнгөн хөрс хуулах явцад чанар муутай уулын чулуулаг, материал орж холилдохоос ямагт сэргийлнэ.
- 4.8. Өнгөн хөрсний хуулалт байр зүйн хувьд өндрөөс нам руу чиглэн явагдана.
- 4.9. Шимт хөрс хуулахын өмнө болон дараа маркшейдерийн хэмжилт хийлгэж, хөндөгдсөн талбайн болон эзлэхүүний хэмжээг долоо хоногийн тайланд, хадгалах талбайд буусан шимт хөрсний хэмжээг сарын тайланд тус бүр тусгана.
- 4.10. Хэрэв маркшейдерийн хэмжилтээр шимт хөрс хуулах гүнд хүрээгүй эсвэл хуулсан хөрсний эзлэхүүн 5-аас дээш хувиар дутуу байгаа тохиолдолд шимт хөрсийг дахин хуулуулж заасан хэмжээнд хүргэнэ.
- 4.11. Салхины хурд 12 метр/секунд-ээс их үед өнгөн хөрсийг хуулах, тээвэрлэх ажиллагааг зогсооно.
- 4.12. Шимт хөрсийг зөвхөн өдрийн цагаар хуулна. Шимэрхэг хөрсийг мөргөцгөөс тээвэрлэх ажилд байгаль орчны мэргэжилтэн, маркшейдер хяналт тавина.
- 4.13. Уурхайн ахилт болон тэлэлт хийхдээ өнгөн хөрсийг хугацаанаас нь эрт хуулахгүй. Шимт хөрсийг хуулсан даруйд төлөвлөгдсөн талбай руу зөөж хадгална.

Тав. Өнгөн хөрсийг хадгалах горим

- 5.1. Өнгөн хөрсийг зөвхөн нөхөн сэргээлтийн зориулалтаар ашиглана.
- 5.2. Шимт хөрсний овоолгын зөвшөөрөгдөх хамгийн дээд өндөр нь 5 метр байна.
- 5.3. Овоолгыг хэлбэршүүлэхдээ хотгор гадаргуугийн талбайг багасгахын тулд шимт хөрсний овоолгын хажуугийн налууг 15 градус, дээд гадаргын налууг 5 градусаас ихгүйгээр тэгшилнэ.
- 5.4. 3 жилээс дээш хугацаанд хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэржүүлж хими-физикийн өгөршил, хөрсний чанарын доройтлоос сэргийлж хөрсний онцлогт тохирсон хамгаалах арга хэмжээг авна.
- 5.5. Өнгөн хөрсний нөөц, хадгалалтын төлөвийн бүртгэлийн тайланг жил бүр хийнэ.
- 5.6. Шимэрхэг чулуулаг болон шимт хөрсийг овоолсон цагаас эхлэн нөхөн сэргээлтэд ашиглах хүртэл жил бүр чанарын болоод бохирдлын шинжилгээнд хамруулж, шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлнэ.
- 5.7. Архив, Газар зүйн мэдээллийн санд өнгөн хөрсний бүх мэдээллийг оруулж хадгална. Үүнд: Байршлын мэдээлэл, шимт хөрсний овоолгын төлөвлөлт, өнгөн хөрс хуулах, овоолго хийх хуваарь, өнгөн хөрс хуулсан талбайн хэмжээ,

овоолгын байршлын зураг, шимт хөрс хуулах зөвшөөрлийн хуудас, хамгаалалтын арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан гэх мэт.

Зургаа. Хариуцлага

- 6.1. Энэ журмын заалтыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.
- 6.2. Гэрээт компанийн ажилтнуудын хувьд энэ журмыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох үндэслэл болно.



ШИМТ ХӨРС ХУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

❖ Хүсэлт гаргагч бөглөнө:

Хүсэлт гаргасан огноо:	Хүсэлт гаргасан хэлтэс/ гэрээт компани:		
Хүсэлт гаргасан ажилтны овог нэр:			
Утас:	Албан тушаал:		
Шимт хөрс хуулах байрлал:	Уурхай ☐	Хотхон ☐	Бусад ☐
Шимт хөрс хуулах байрлал /бичгээр/:			
Байрлалын талаарх нэмэлт тайлбар:			
Зориулалт:			
Шимт хөрс хуулах талбай:	га	м ²	
Хуулагдах шимт хөрсний хэмжээ (м ³):	Байршуулах овоолгын дугаар:		
Байршуулах овоолгын талаарх нэмэлт тайлбар:			
Шимт хөрс хуулж эхлэх огноо:			
Дуусах огноо:			
Хариуцах ажилтны овог нэр:			
Албан тушаал:		Холбоо барих утас:	

❖ Бусад мэдээлэл:/Байгаль орчны мэргэжилтэн бөглөнө/

Газрын хэлбэр:	Тал газар ☐	Хонхор газар ☐	Гүвээ ☐	Бусад ☐
Унд, ахуйн болон бусад усны эх үүсвэрт ойр байгаа эсэх?			Тийм ☐	Үгүй ☐
Ховордсон амьтан ургамал өртөх эсэх?			Тийм ☐	Үгүй ☐
Бохирдол хязгаарлах арга хэмжээ авагдах шаардлагатай эсэх?			Тийм ☐	Үгүй ☐
Тоосны эх үүсвэрийг багасгах шаардлагатай эсэх?			Тийм ☐	Үгүй ☐
Шимт хөрс хуулах гүн (см):		Шаардлагатай тохиолдолд хуулах гүн (см):		
Шөнийн цагаар хуулах шаардлагатай эсэх				
Ажлын явцад байгаль орчны нөлөөллийг хянах талаар тэмдэглэл:				
Байгаль орчны нөхцөл байдлын талаар тэмдэглэл:				
Ховор ургамлын мэдээлэл:				
Хамгаалах арга хэмжээний талаар:				

❖ Мэргэжилтнүүд бөглөнө:

Хариуцлагатай ажилтны зөвшөөрөл (Гарын үсэг зурж зөвшөөрөл өгснөөр баталгаажуулна):			
Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Огноо
Байгаль орчны мэргэжилтэн:			
Төлөвлөлтийн инженер:			
Хариуцан хийх албан тушаалтан:			


❖ **Хяналт шалгалт: /ЭТТ-ийн байгаль орчны мэргэжилтэн бөглөнө/**

Сар, өдөр	Хуулалт	Тээвэрлэлт	Тайлбар	Гарын үсэг

❖ **Маркшейдерийн хэмжилт:**

Сар, өдөр	Хуулсан м3	Хуулах м3	Мэргэжилтэн	Гарын үсэг

Хөрс хуулах төлөвлөгөөний зураг: Хавсралтаар үзүүлэв



ШИМТ ХӨРСНИЙ АКТ



❖ Хүсэлт гаргагч бөглөнө:

Хүсэлт гаргасан огноо:		Компани:		№	
Хүсэлт гаргасан ажилтны овог нэр:					
Утас:		Албан тушаал:			
Шимт хөрс хуулах байрлал:		Уурхай ☐	Хотхон ☐	Бусад ☐	
Шимт хөрс актлах байрлал /бичгээр/:					
Байрлалын талаарх нэмэлт тайлбар /координат/:					
Шимт хөрс актлах талбай:		га		м ²	

❖ Байгаль орчны хэсэг бөглөнө:


Газрын хэлбэр:	Тал газар ☐	Хонхор газар ☐	Гүвээ ☐	Бусад ☐
Унд, ахуйн болон бусад усны эх үүсвэрт ойр байгаа эсэх?			Тийм ☐	Үгүй ☐
Ховордсон амьтан ургамал өртөх эсэх?			Тийм ☐	Үгүй ☐
Бохирдол хязгаарлах арга хэмжээ авагдах шаардлагатай эсэх?			Тийм ☐	Үгүй ☐
Тоосны эх үүсвэрийг багасгах шаардлагатай эсэх?			Тийм ☐	Үгүй ☐
Шимт хөрс актлах шалгаан, үндэслэл дэлгэрэнгүй:				
Холбогдох шимт хөрс хуулах зөвшөөрлийн талаарх мэдээлэл:				

❖ Мэргэжилтнүүд бөглөнө:

Хариуцлагатай ажилтны зөвшөөрөл (Гарын үсэг зурж зөвшөөрөл өгснөөр баталгаажуулна):

ЭТТ Байгаль орчны мэргэжилтэн:		Огноо:	
Хүсэлт гаргасан ажилтан		Огноо:	

❖ **Хөрс актлах төлөвлөгөөний зураг:**

Хөрс актлах төлөвлөгөөний зураг:


Журмын хяналтын хуудас

Баримт бичгийн нэр	Өнгөн хөрстэй ажиллах журам
Баримт бичгийн код	ЭАР-БО-Ж08-И/18
Тодорхойлолт	Уурхайн олборлолт, бүтээн байгуулалтад өртөж байгаа талбайгаас шимэрхэг чулуулаг болон шимт хөрсийг нөхөн сэргээлтийн зориулалтаар ашиглахад зориулж хуулах, хадгалах технологийг тодорхойлох
Анхны зохиогч	Ш.Намсрайжав, Г.Анх-Амгалан /Байгаль орчны мэргэжилтэн/
Үүсгэсэн огноо	
Баталсан албан тушаалтан*	
Баталсан огноо*	

Нэмэлт өөрчлөлт

Хувилбар	Хянан засварласан огноо	Хянасан	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1				
2				

* Журам, горим, зааврын хамгийн эхний хувилбарыг баталж буй тохиолдолд бөглөнө.